

“ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ  
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА” СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Улаанбаатар хот

2021 он

**Судалгааны захиалагч:**

**Судалгааны багийн ахлагч:**

Б.Галбадрах

Дотоод хэргийн их сургуулийн  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,  
Хууль зүйн доктор /Ph.D/

**Судалгааны багийн гишүүд**

Г.Хосбаяр

Дотоод хэргийн их сургуулийн  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын  
тэнхимийн ахлах багш, Хууль зүйн магистр

Э.Өнөболд

Мөн тэнхимийн багш, Хууль зүйн магистр

**Судалгааг хянасан:**

Б.Батболд

Дотоод хэргийн их сургуулийн  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн  
захирал, Удирдахуйн ухааны магистр

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт

Ерөнхий мэдээлэл

Урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийн тодорхойлох

1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

4.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуультай нийцэж байгаа эсэх

Тав. Зохицуулалтуудын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Зургаа. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт

Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны талаарх Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудаас түүвэрлэсэн судалгаа

Оросын Холбооны Улсын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн тухай холбооны хууль /орчуулга/  
Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургуулиудын болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль /орчуулга/

## Товчилсон үгийн жагсаалт

БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ДХГ	Дотоодыг хамгаалах газар
ДЯЯ	Дотоод явдлын яам
НАХЯ	Нийгмийг аюулаас хамгаалах яам
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ДХЯ	Дотоод хэргийн яаи

## **Ерөнхий мэдээлэл:**

Монгол Улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд эрх зүйн шинэтгэлийн хөгжилд анхаарлаа хандуулсаар ирсэн. Эрх зүйн шинэтгэл тэр дундаа эрх зүйн боловсролын шинэтгэлийн асуудал өөрчлөгдөн шинэчлэгдсээр хөгжлийн зохих түвшинд хүрээд байгаа хэдий ч бүс нутгийн үүнээс цаашлаад дэлхийн түвшинд өрсөлдөх хэмжээний хүний нөөцийг бэлтгэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод дэлхийн хэмжээний их сургуулийг байгуулах нь нийслэлийн бүрдүүлэгч нэг хэсэг, мөн манай улсын шинжлэх ухаан, боловсролын салбарын чадавхийг үр дүнтэй хөгжүүлэх ажил болсон.

Тус сургууль үүсгэн байгуулагдсан 1930-аад оны эхэн үе бол дэлхий дахинаа олон улсын байдал хүндэрсэн, бүс нутаг, БНМАУ-ын дорнод хил орчим гадаадын милитаризм, эзлэг түрэмгий бодлогын аюул бодитой нүүрлэсэн, дотоодод ангийн тэмцэл хурцадсан, лам нарын бослого, хөдөлгөөн идэвхэжсэн, ард иргэд олноор дүрвэн нүүж байсан, шинэ тутам байгуулагдсан Бүгд Найрамдах Улсын бодлого, үйл ажиллагаа эрсдэл, сорилтой учирсан түгшүүртэй он жилүүд байлаа<sup>1</sup>.

85 жилийн өмнө Дотоод хэргийн их сургууль нь Дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар ДХГ, Хязгаарын цэрэгт боловсон хүчин бэлтгэх дунд сургуулийг “Төв сургууль” нэртэйгээр анхны 60 гаруй суралцагчдад үүд хаалгаа нээж 3 салаа болгон зохион байгуулж байсан. Эдгээр он жилүүдэд манай улсын дээд боловсролын тогтолцоонд шинийг нэвтрүүлэх бусад тэргүүлэх их, дээд сургуулиудтай өрсөлдөх хэмжээний сургуулийг бий болгох зорилго материаллаг суурь хэмжээнд биелсэн гэж үзэж болно.

Улс орны гадаад, дотоод нөхцөл байдалтай холбоотойгоор тус сургууль нь бүтцийн хувьд өргөжиж 1938 онд Бүх цэргийн жанжин; ДЯЯ-ны сайдын тушаалаар “Дотоодын ба Хязгаарын нэгдсэн сургууль”; 1970-аад оны эхэн үед БНМАУ-ын засаг захиргааны нэгж болох сум бүрт хэсгийн төлөөлөгчтэй болох, эрүү, өмч, сэргийлэн хамгаалах албыг бэхжүүлэх, хилийн цэргийг өргөтгөх, засан хүмүүжүүлэх ажлыг шинэ шатанд гаргах, хууль цаазын болон цэрэг-улс төрийн тусгай мэргэжил бүхий офицерыг олноор бэлтгэх шаардлагын үүднээс НАХЯ-ны сайдын тушаалаар Цэргийн тусгай дунд сургуулийг; 1980 оны зааг дээр НАХЯ-ны сайдын тушаалаар НАХЯ-ны Цэргийн дээд сургууль; харин 1990 онд Монгол Улс зах зээлийн эдийн засгийн хэлбэрт шилжин, улс төр, нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс Монгол Улсын цагдаагийн байгууллага шинэ сорилтой тулгарч 1992 онд Цагдаагийн дээд сургууль; 2000 онд Цагдаагийн академи болгон өргөжиж зохион байгуулсан.

Төрөөс суралцах орчныг бүрдүүлсэн орчин үеийн сургуулийг байгуулахад бүх талын туслалцааг үзүүлсэн бөгөөд Их сургуулийн төв байрыг 2016 онд ашиглалтад

---

<sup>1</sup> Б.Бат-Эрдэнэ. ДХИС-ийн 85 жилийн түүхэн замнал, ололт амжилт /Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2019. 6 тал/.

оруулж, Их сургуулийн төв номын сан, спорт цогцолборыг 2020 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Эдгээр он жилүүдэд Их сургууль нь өсөн дэвжсэн бөгөөд өнөөдөр Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургууль, Ахисан шатны боловсролын сургууль, Удирдлагын академи, Шинжлэн магадлахуйн институт, Ерөнхий боловсролын ахлах сургууль гэсэн бүрэлдэхүүн 10 сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн; Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар; Цэргийн албаны тусгай факультет; Хангамж, үйлчилгээний газар бусад алба нэгжийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн боловсрол, бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын хэлбэрээр, 50 гаруй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, судалгааны тэргүүлэх 30 орчим чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж, гадаадын 30 гаруй дотоодын 10 гаруй их, дээд сургууль; 50 гаруй байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургууль нь 470 гаруй багш, алба хаагч, ажилтантай; 4000 гаруй суралцагчтай, магистр, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлтэй; сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг үндэсний хэмжээний их сургууль болон өргөжиж байна.

Өнөөдөр Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид Монгол Улсын өнцөг, булан бүрд үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт явдалтай тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, хилийн халдашгүй байдлыг хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гамшгаас хамгаалах, шинжлэх магадлах ажлыг нэр төртэйгээр биелүүлж; дэлхийн нэр хүндтэй сургуулиудад үргэлжлүүлэн суралцаж байна.

Дотоод хэргийн их сургууль нь байгуулагдсан цагаасаа дэлхийн төвшний, эрдэм шинжилгээ, сургалтын бат бөх суурьтай сургууль болохоо харуулсанг сургуулийн ололт, амжилтын талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаачид 2019 оны 07 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр үзэл бодлоо хуваалцсан байдаг.

Их сургуулийн өмнөх он жилүүдэд гаргасан амжилт нь мянга мянга хүний хичээл зүтгэлийн үр дүнд бий болсон бөгөөд цаашид ч үргэлжлэх ёстой.

Монгол Улсын Их хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/-ын 3.15 дахь хэсэгт “Боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагын академик эрх чөлөөг хангана” гэж заасан<sup>2</sup>тай уялдуулан Дотоод хэргийн их сургуульд тогтсон дэг, сургуулиудыг хадгалан үлдэх, алба хаагчдын эрх зүйн байдлыг бататгах, **академик** эрх чөлөөг бататгах хууль, эрх зүйн орчин шаардлагатай байгаа юм.

---

<sup>2</sup> Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // <https://www.legalinfo.mn/annex/details/6661?lawid=10935>

## **Урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан**

Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### **Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал**

Аливаа нийгмийн харилцааг хууль, эрх зүйн актаар зохицуулснаар заавал дагаж мөрдөх хэм хэмжээг бий болгож тухайн харилцаанд үүсч байгаа доголдол, аливаа эрсдэлийг багасгаж нийгмийн сайжруулалт, өөрөөр хэлбэл өөрчлөлтүүд хийгдэж байна.

Монгол Улсад өрнөж буй шинэчлэлийн үйл явц нь дээд боловсролын салбарын хөгжлийн сонгодог загвар, түгээмэл зүй тогтол, тэргүүний жишигт ойртуулахад чухал түлхэц болсоор байна. Шилжилтийн, мөн даяаршлын үйл явцтай хөл нийлүүлэн энэ он жилүүдэд монголын боловсролын салбарт эрс шинэчлэлт хийгдсэн бүх шатны сургалтын хэлбэр, агуулга өөрчлөгдөж, уг салбарт хувийн салбар үүсэхийн сацуу түүний эзлэх хувийн жин огцом нэмэгдэж, түүнийг дагасан боловсролын тогтолцооны тэлэлт бий болов.

Боловсролын салбарт шинэлэг технологиуд бий болж, дэлхийн тэргүүний жишгээс суралцах, ижилсэх, тэдгээртэй хорших, оюуны сүлжээ үүсгэх, багшийн хөгжилд онцгой анхаарал хандуулах, ялангуяа их, дээд сургуулийн багш нарын шинэ үеийг бэлтгэх чиглэлд бодитой ахиц гарсаар байгаа билээ. Шинэчлэлийн явцад боловсролын, түүн дотроо дээд боловсролын салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчин үндсэндээ шинээр бүрдсэн бөгөөд энэ хугацаанд Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль тогтоомжид хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулж, үүнтэй холбоотойгоор боловсролын тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд зарчмын шинжтэй алхмууд хийгдсэн байдаг. Эдгээрийн гол жишээ бол “Боловсрол” үндэсний хөтөлбөр /2010-2021/, “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /2010-2021/”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/” зэрэг бөгөөд боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тулгуур хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ... гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улс нь Азийн орнуудын дунд нэлээдгүй хугацааны өмнө шинэчлэлийн замыг сонгосон. Эдийн засгийн хямрал нь боловсролын салбарт оновчтой хөгжлийн чигийг сонгоход хүндрэл учруулсан бөгөөд олон цэцэрлэг, мэргэжил сургалтын төвүүд хаалгаа барихад, багш нар ажил хаяхад хүргэсэн байдаг. Үүний сацуу өндөр үр нөлөөтэй боловсролын систем нь улс орны тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл болдог бөгөөд шинэчлэлийн үйл явц нь хууль эрх зүйн, шинжлэх ухаан, арга зүйн,

материаллаг орчныг бүрдүүлэхийг шаарддаг. 2000 оны эхэн үед ЮНЕСКО нь Монгол Улсыг боловсролын хувьд асуудалтай орны жагсаалтад оруулсан байдаг<sup>3</sup>.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Боловсрол” үндэсний хөтөлбөрийн /2010-2021 он/ стратегийн зорилт 5-ын 3 дахь хэсэгт “их сургуулийн эрх зүйн байдлын талаар хуулийн төсөл боловсруулах” гэж заасан байдаг<sup>4</sup>. Энэ нь гадаадын орны жишгийг дагасан Их сургуулийн бие даасан байдлыг хангасан, тогтвортой байдлыг хангах зохицуулалт болох юм. Үүнээс гадна Дээд боловсролын шинэчлэлийн зураглалын хүрээнд дээд боловсролын салбарын эрх зүйн орчинг сайжруулах, санхүүжүүлэлтийн тогтолцоог шинэчлэх шаардлагатай гэж үзэн Дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт-2021-д Дээд боловсролын эрх зүйн орчны шинэчлэлийн бодлогын хүрээнд “Их сургуулийн бие даасан байдал, академик эрх чөлөөг баталгаажуулах” гэсэн стратеги зорилтыг дэвшүүлсэн байна<sup>5</sup>.

Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар:

- “Боловсрол” үндэсний хөтөлбөрийн /2010-2021/ стратегийн 5 дахь зорилт хангагдана;
- Улсын томоохон төрийн өмчит их, дээд сургуулиудад үлгэр дууриал болно;
- Дотоод хэргийн их сургуульд шинэ үүрэг оногдоно: өөрийн жишээгээр салбар бүрт ажиллах загварыг харуулах, эрдэм шинжилгээний, сургалтын болон иновацийн хүрээг тэлэх;
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг бие даан боловсруулах эрх зүйн орчин бүрдэнэ;
- Нийгмийн хэрэгцээнээс хамаарч уян хатан болно. Өндөр түвшний сургалтын үйлчилгээг үзүүлнэ;
- Үндэсний суурь жишиг /дэг/ сургуулиудыг хадгалж үлдэнэ;
- Их сургуулийн удирдлага, багшлах бүрэлдэхүүний тогтвортой байдал хадгалагдана;
- Их сургуулийн удирдлага, удирдах бүрэлдэхүүний эрх мэдлийн хуваарилалт оновчтой болсон байна;
- Их сургуулийн алба хаагчдын эрх зүйн байдал баталгаажна;
- Их сургуулийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдэнэ;
- Их сургуулийн хамтын ажиллагааны эрх зүйн орчин бүрдэнэ;

---

<sup>3</sup> [https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245745\\_rus](https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245745_rus)

<sup>4</sup> “Боловсрол” үндэсний хөтөлбөр /2010-2021 он/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // <https://www.legalinfo.mn/annex/details/2599?lawid=5436д>

<sup>5</sup> Дээд боловсролын шинэчлэлийн зураглал // Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас. URL: <https://mecss.gov.mn/page/41/>

- Их сургуулийн үйл ажиллагааны нууц хадгалалт баталгаажна;
- Их сургуулийн санхүүгийн бие даасан эрх зүйн орчин бүрдэж суралцагчдын тэтгэлгийн сан үүснэ.

Энэ хууль нь эрх ямба олгосон бус хариуцлагыг өндөржүүлэх хууль болох юм гэдгийг онцлох нь зүйтэй.

Хуулийн төсөл нь шинэ бүтцийг боловсруулах нэг алхам юм.

Иймд, Аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

### **1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:**

Сүүлийн жилүүдэд судлаачид их сургуулийн бие даасан байдлыг хангах зайлшгүй шаардлагатайг онцолж ирсэн бөгөөд тусгай хууль тогтоомжоор төрийн өмчийн их сургуулиудад нийтийн статус олгох, эрх тэгш хөгжих боломжоор хангах асуудлыг хөндсөөр байна. Үүнд:

1. Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 10 агентлаг, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Дотоод хэргийн их сургуулийн хувьд байгууллагын статустай хэдий ч Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын захиалгаар мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэж байгаа бөгөөд Дээд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль гэх мэт салбар хууль тогтоомжуудыг удирдлага болгон ажилладаг. Харин хүний нөөцийн захиалагч байгууллагуудын үйл ажиллагаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, салбарын эрх зүйн баримт бичгээр зохицуулагддаг.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын удирдлагыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг. Дотоод хэргийн их сургуулийн хувьд статусаас хамааран ийм төрлийн хугацаа заасан нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй, Монгол Улсын Засгийн газрын тухайн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх дэд хэсэгт “хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө” гэж заасны дагуу зохицуулагдаж байна.

3. Дотоод хэргийн их сургуулийн алба хаагчид төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын цол, дүрэмт хувцсыг хэрэглэдэг хэдий ч бусад байгууллагатай харьцуулахад алба хаагчдын эрх зүйн байдал харилцан адилгүй.

4. Дотоод хэргийн их сургуульд Цагдаагийн байгууллагын цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа алба хаагчдын албан ажлын онцгой нөхцөлийн, цолны нэмэгдэл Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор, Хил хамгаалах байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа алба хаагчдын цэргийн цолны нэмэгдлийн хэмжээ Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолоор, Онцгой байдлын байгууллагын цол дүрэмт хувцас хэрэглэдэг алба хаагчдын нэмэгдэл Засгийн газрын 2005 оны 77 дугаар тогтоолоор, сүүлийн 3 байгууллагын цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа алба хаагчдын алба ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2013 оны Б/07 дугаар тушаалаар зохицуулагдаж нэмэгдлий хэмжээ харилцан адилгүй байна.

5. Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлах сургуульд суралцагчид сургалтын төлбөр төлдөг бөгөөд тэдэнд тэтгэлэг, хөнгөлөлт олгох талаар судлах.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд батлагдсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг бусад төрийн зарим чиг үүрэг бүхий байгууллагатай харьцуулбал хамрах хүрээ их, алба хаагчийн орон тооны дээд хязгаараас илүү байгаагаас үзвэл төрийн тусгай чиг үүрэг бүхий алба хаагч, хүний нөөцийг бэлтгэн гаргадаг онцлогийг харгалзан үзэж цаашид тус их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай байж болох зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байж болох талтай. Өөрөөр хэлбэл Дотоод хэргийн их сургуулийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох хэрэгцээ, шаардлага бий болсон гэж үзэж байна.

Хэрэв Дотоод хэргийн их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай болбол Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөгдсөн ч Их сургуулийн алба хаагчид нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн баталгаагаар хангагдана. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасан *“Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно”* гэсэн хууль зохицуулалт үйлчлэх юм.

## **1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийн тодорхойлох:**

Дотоод хэргийн их сургуулийн тухай хуулийг баталснаар тус хуулийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөх алба хаагчид, суралцагчдын хувьд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхгүй, харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор их сургуулийн үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэж, удирдлага, алба хаагчид, суралцагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол баталгаажна.

### 1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

*Дотоод хэргийн их сургуулийн хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн байдлыг авч үзье:*

1. Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Цагдаагийн академи байгуулах тухай” 17 дугаар тогтоолоор Цагдаагийн дээд сургуулийг цагдаагийн анхан шатны, үндсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг давтан сургах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чиг үүрэгтэй Цагдаагийн академи болгон өөрчлөн зохион байгуулж, Цагдаагийн академийн бүтэц болон дүрмийг баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайдад даалгасан.

2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэрэг, тагнуулын салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургуулийн байгуулсан. Энэхүү тогтоолоор Дотоод хэргийн сургуулийн удирдлагыг 2011 оны 8 дугаар сард багтааж томилохыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.

3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Дотоод хэргийн их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 243 дугаар тогтоолоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг орон тоо, төсвийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуульд шилжүүлсэн. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цагдаагийн академи” байгуулах Засгийн газрын 2000 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар тогтоол, “Хилийн цэргийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 126 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчин төгөлдөр болгосон байдаг.

Гэхдээ эдгээр өөрчлөлтүүд нь зөвхөн статусын хүрээнд өөрчлөгдсөн бөгөөд эрдэм шинжилгээний үйл ажиллагаа чиглэл тэлж, статусын хувьд өргөжиж дээд сургуулиас академи, академиас их сургууль болон өөрчлөгдсөн байгаа юм<sup>6</sup>.

4. “Дотоод хэргийн их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай” 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан, Хууль сахиулахын их сургуулийн захирлыг 2012

---

<sup>6</sup> Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлж болно; 4.3 дахь хэсэгт Дээд сургууль нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага мөн. Дээд сургууль нь магистрын сургалт эрхэлж болно гэж заасан байдаг.

оны 10 дугаар сард багтаан томилж, *бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг* баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайдад даалгасан байдаг.

5. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Хууль сахиулахын их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай” 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийг Дотоод хэргийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан. Ингэснээр сургалтын хөтөлбөрийн агуулга, чанарыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд нарт үүрэг болгосон байдаг.

Дээр дурдсан Монгол Улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудыг судалж үзвэл, Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх болгонд тус их сургуулийн хуулийн этгээдийн нэршил өөрчлөгдөх, түүнчлэн Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, албан хэрэг хөтөлөлтөд өөрчлөлт орж, улмаар боловсролын индексэд өөрчлөлт орох, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох, цаашлаад сонсогч, суралцагчдын сурлагын чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзэж байна. Үүнээс гадна гадаадын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд тухайн сургуулиудаас манай сургуульд хандахад хүртэл тодорхой хэмжээгээр хүндрэл учирдаг жишээ гарсаар байна.

Гэтэл гадаадын их, дээд сургуулиудын хуулийн этгээдийн нэрийг ойр ойрхон өөрчлөх тохиолдол төдийлөн ажиглагддаггүй бөгөөд үйл ажиллагаа, статусын хувьд өргөжиж дээд сургуулиас академи, академиас их сургууль болон өөрчлөгддөг зүй тогтолтой.

6. Дотоод хэргийн их сургуульд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 3 агентлаг /Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар/, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх хүрээний 1 агентлагийн /Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газар/ цол дүрэмт хувцас хэрэглэдэг алба хаагчид ажиллаж байна. Үүнээс хамаарч алба хаагчдад олгож байгаа албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, цолны нэмэгдлийн хувь хэмжээ харилцан адилгүй байна.

Харьяа агентлагуудын цол, дүрэмт хувцсыг хэрэглэж байгаа алба хаагчдын судалгаа  
*/2019 оны байдлаар/*

№	Агентлаг	Хүний тоо	Хувь
1	Цагдаагийн байгууллага	218	46.1
2	Хил хамгаалах байгууллага	101	21.4
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	43	9.1

4	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага	28	5.9
5	Дотоодын цэрэг	3	0.6
6	Энгийн	80	16.9

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн “Хууль сахиулахын их сургуулийн талаар авах арга хэмжээний тухай” 240 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга болон сургалтын чанар, орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн сайжруулах, багш нарыг мэргэшүүлэх төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг зохион байгуулах; Хууль сахиулахын их сургуулийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоож, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, дүрмийг шинэчлэн баталж мөрдүүлэх; Хууль сахиулахын их сургуулийн албан хаагчийн дүрэмт хувцас хэрэглэх, тэдгээрт цол олгох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайдад даалгасан байдаг. Тэр дундаа Хууль сахиулахын их сургуулийн албан хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцөлийн, цол, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тус тус цагдаагийн албан хаагчид олгож байгаа нэмэгдлийн хувь, хэмжээтэй адилтган тооцон олгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт үүрэг болгосон байдаг. Гэсэн хэдий ч хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа алба хаагчдын нэмэгдлийн хувь цагдаагийн байгууллагын цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа алба хаагчдынхтай адилгүй байна.

Цолны нэмэгдлийн хувь хэмжээний хувьд  
/Сар бүр олгох нэмэгдлийн хувь хэмжээ, үндсэн цалингийн хувиар/

Байгууллага /цол хэрэглэж байгаа/	Журам	Цол								
		д/а	а/ч	а/а	д/ч	а/д	а/х	х/ч	д/х	х/а
Цагдаагийн байгууллага	Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоол	25			30					
Хил хамгаалах байгууллага	Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоол	20	22	24	26	28	30	32	34	36

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага										
---------------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--

Үүнээс эдгээр байгууллагын цол хэрэглэдэг ахлагч бүрэлдэхүүн буюу бага цолны, дунд офицерын цолны дэслэгч, ахлах дэслэгч цолны хувь хэмжээ харилцан адилгүй байгааг харж болох юм. Харин цэргийн ахлах офицерын ангилалд багтах цол хэрэглэдэг алба нэмэгдлийн хувь хэмжээ цагдаагийн цол хэрэглэдэг алба хаагчдынхтай харьцуулахад илүү байна.

Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хувьд  
/Сар бүр олгох нэмэгдлийн хувь хэмжээ, үндсэн цалингийн хувиар/

Байгууллага /цол хэрэглэж байгаа/	Журам	Нэмэгдлийн хэмжээ /хувь/
Цагдаагийн байгууллага	Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоол	Ахлагч /15/
		Офицер /20/
Хил хамгаалах байгууллага	Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2013 оны Б/07 дугаар тушаал	Ажилтан, алба хаагч /10/
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага		Нэгжийн дарга /15/
Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага		Захирлын зөвлөлийн гишүүд /20/

Хүснэгтээс харахад багш, алба хаагчдын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ харилцан адилгүй байна.

7. Дотоод хэргийн их сургуульд захиалагч байгууллагын захиалгаар бэлтгэгдэж байгаа хүний нөөцийн ажиллаж байгууллагын алба хаагчдыг эрх зүйн байдал Төрийн албаны хуулиас гадна салбарын хуулиар тусгайлан зохицуулагдсан байдаг. Тухайлбал, Цагдаагийн байгууллага – Цагдаагийн албаны тухай хууль, Хил хамгаалах байгууллага – Монгол Улсын хилийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага – Гамшгаас хамгаалах тухай хуулиар. Харин Дотоод хэргийн их сургуулийн хувьд зөвхөн Төрийн албаны хуулиар зохицуулагдаж байгаа нь төрийн тусгай алба хаагчдын хувьд эрх зүйн байдлыг төдийлөн анхаараагүй байгаа нь харагдаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхой хүрээг Их сургуулийн дүрмээр зохицуулдаг бөгөөд Улсын Их Хурлаас батлагдсан

хууль болон Засгийн газрын хууль зүйн асуудал хариуцсан гишүүний баталсан дүрмийн үйлчлэх хүчин чадал харилцан адилгүй байх нь ойлгомжтой.

8. Дээд боловсролын тухай хуульд 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр /6.2-р зүйл/ төрийн өмчийн их, дээд сургуулиудын захирлыг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг тухайн төрийн өмчит сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд олгосон байдаг бөгөөд, эргээд хариуцлага тооцдог байх тогтолцоог бүрдүүлсэн билээ. Мөн төрийн өмчийн их, дээд сургуулийн Удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл 30 хувь, хараат бус гишүүдийн төлөөллийг 40 хувь байхаар зохицуулсан байв.

Энэхүү шинэлэг өөрчлөлт нь төрийн өмчийн их сургуулиудын бие даасан байдлыг хангаж, их сургуулийн засаглал, түүний тогтвортой байдлын бэхжүүлэх зорилгоор хийсэн эрх зүйн зохицуулалт байсан. Үүнтэй холбогдуулан Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган нарын тэмдэглэснээр, “...хараат бус гишүүдийн оролцоог мэдэгдэхүйц нэмэгдүүлснээр улс төрийн албан тушаал хашдаггүй, эдийн засаг болоод оюуны хувьд тухайн сургалтын байгууллагад их хэмжээний хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг үзүүлэх чадвартай хувь хүмүүсийн төлөөлөл Удирдах зөвлөлд ажиллах боломж нэмэгдсэн юм”<sup>7</sup>. Гэтэл 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Дээд боловсролын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай” хуулиар эдгээр эерэг өөрчлөлтүүд ердөө найман сарын дараа хүчингүй болсон юм.

Үүнээс харахад төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын бие даасан байдал чухал байгаа бөгөөд Дотоод хэргийн их сургуулийн захирлыг удирдах зөвлөлөөс томилдог байхыг шаардахгүй бөгөөд энэ нь Засгийн газрын тухай хуулийн зарим заалттай зөрчилдөж байна. Гагцхүү тус сургуулийн захирлын тогтвортой байдал чухал.

*Шигтгээ. Дотоод хэргийн их сургуулийн захирал тогтмол солигддог. Дараах хүснэгтийг зөвхөн Их сургууль байгуулагдсан цагаас хойших захирлуудыг нэрлэсэн болно. 2019 оны 12 дугаар сард иргэдийн дунд боловсролын чанарыг нэмэгдүүлэхэд ямар хүчин зүйл шаардлагатай вэ? асуулгад “удирдлагын хүчтэй байдал” гэж хариулсан байдаг.*

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 5.3 дугаар хэсэгт “Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан байдаг”<sup>8</sup>.

---

<sup>7</sup> Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл.

<sup>8</sup> Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // <https://www.legalinfo.mn/annex/details/6661?lawid=10935>

Их сургуулийн захирлын томилгооны харьцуулалт /2011-2019 он/

№	Нэр	Ажилласан хугацаа
1	Б.Болдбаатар	2011-2013
2	Р.Чингис	2013-2015
3	С.Баатаржав	2015-2017
4	Ө.Энхтөр	2017-2019

Дотоод хэргийн их сургуулийн захирал нь 2 жил тутам зарим тохиолдолд 1 жил ажиллаад солигдож байгаа нь тогтвортой байдлыг алдагдуулж байна гэж үзэж болох юм.

Үүнээс гадна тус Их сургуулийн захирал нь их сургуулийн алба хаагчдыг томилох, шилжүүлэн томилох, чөлөөлөх эрхтэй боловч тэдэнд цагдаагийн цол болон цэргийн цол олгох эрх олгосон эрх зүйн зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, цол олгуулах, цол бууруулах асуудлыг тухайн төв байгууллагын даргад уламжилж шийдвэрлүүлж байна. Б.Батболд өөрийн илтгэлдээ тухайн байдалд дүгнэлт хийж Их сургуулийн захирлын албан тушаалыг эрх зүйн чадамжгүй менежерийн албан тушаал гэж ч тодорхойлсон байдаг<sup>9</sup>.

9. 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдөр УИХ-аас баталсан Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3. дахь хэсэгт төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын эдийн засгийн бие даасан байдлыг хангах, дэмжих дараах чухал зохицуулалт орж батлагдсан байдаг: “5.3.1.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, Боловсролын тухай хуулийн 43.1.4–т заасан зардлыг санхүүжүүлэх; 5.3.2. Засгийн газраас тодорхойлсон чиглэл, шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх; 5.3.3. улсын төсвөөс хуваарилсан хэмжээгээр Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг санхүүжүүлэх; 5.3.4. дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах зардлыг санхүүжүүлэх.” Гэвч эдгээр заалтаас 5.3.3-аас бусад бүх заалтыг 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон нь урагш нэг алхаж буцаж хоёр алхсан явдал болсон гэж дүгнэхэд хүргэж байна.

Дээд боловсролын салбар дахь корпорэт засаглал нь оролцогч талуудын эрх ашгийн зохистой тэнцвэрийг хангах боломжийг олгодог удирдлагын хэв шинж мөн бөгөөд уг засаглалын давуу тал нь урт хугацааны хөгжлийн бодлогыг баримтлан хөрөнгө оруулж, санхүүжүүлэгч болон оюутан суралцагсдын өмнө хариуцлага

<sup>9</sup> Б.Батболд Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2019. № 03 (30). 20 тал.

хүлээдэгт, түүнчлэн ил тод байдлыг чухалчилдагт оршдог. Ийм нөхцөлд CEO хэв шинжийн лидер удирдлагыг хэрэгжүүлж, их сургуулийн стратегийн бодлого, зохион байгуулалтыг гартаа атгаж байдгаараа бие даасан байдлыг хангах, эрх ашгийн төлөөлөл, нийгмийн өмнө хариуцлага хүлээх чадвараар илүү хэмээн судлаачид ч үзсэн байдаг.

### **Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал**

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Дотоод хэргийн их сургуулийн бие даасан байдал, алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох замаар практикт үүсэж буй тодорхой асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад оршино.

### **Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал “Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, бие даасан байдлыг бүрдүүлэх, алба хаагчдын эрх зүйн байдлыг бататгах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

<b>Хувилбар</b>		<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>	<b>Үр дүн</b>
1	<i>Тэг хувилбар</i>	Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлууд хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар нэмэгдэх магадлалтай.	Үр дүн сөрөг
2	<i>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх</i>	Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлуудыг таниулах боломжтой.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад жижиг хэмжээнд нөлөө үзүүлэх магадлалтай.	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.
3	<i>Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх</i>	Эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад жижиг хэмжээнд нөлөө үзүүлэх магадлал бага.	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.
4	<i>Төрөөс санхүүгийн интервенц хийх</i>	Дотоод хэргийн их сургуулийн үйлчилгээний чанарыг сайжруулах санхүүжилтийн асуудлыг	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад жижиг хэмжээнд нөлөө	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.

		шийдвэрлэсэнээр зарим талаар байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	үзүүлэх магадлал бага.	
5	<i>Захиргааны шийдвэр гаргах</i>	Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааг зохицуулсан олон тооны дүрэм, журмыг баталж тодорхой асуудлыг шийдвэрлэж болох хэдий ч Их сургуулийн бие даасан байдал, алба хаагчдын эрх зүйн байдлыг бататгаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зорьж буй үр дүнд бүрэн хүрч чадахгүй.
6	<i>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах</i>	Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааны шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод бүрэн хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанарын харгалзан үзэж Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал**

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонсон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. /Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2,3, 4-өөс үзнэ үү/.

##### **4.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Тогтвортой ажлын байр, сургалтын үйлчилгээг санал болгох замаар Монгол Улсын Үндсэн хуулиар тунхаглагдсан хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, сурч боловсрох, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих зэрэг гол гол эрхүүдийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

##### **4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Эрх зүйн зохицуулалтын хувьд Дотоод хэргийн сургуулийн эрх зүйн байдлын тухай хуультай болсноор эдийн засагт ачаалал үүсгэхгүй, байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд зохицуулалт хийх байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

#### **4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор иргэд өдөр тутам Дотоод хэргийн их сургуулиас хэрэгтэй мэдээллийг түргэн шуурхай, чирэгдэлгүй авна.

#### **4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.**

Дээд боловсролын тухай хуулийн 5.1., Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Их сургууль нь профессорын багт тулгуурласан зохион байгуулалтын нэгжтэй байж болно; 5.7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр тодорхой аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт-эрдэм шинжилгээ, дадлагын бааз болгож болно; Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг их сургууль, дээд сургууль, коллежийн дүрмээр тогтооно; 11.1. Ашгийн төлөө бус төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг тухайн сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ; Төрийн албаны тухай хуулийн 7.1. Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

7.1.1.ард түмэнд үйлчлэх;

7.1.2.мэргэшсэн, тогтвортой байх гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Дээд боловсролын тухай, Төрийн албаны тухай хуулийн агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна.

#### **Тав. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт**

Аргачлалын 7-д заасан хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилтод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулах дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

### **Зургаа. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал.**

Бусад орны эрх зүйн систем, их сургуулийн тухай хуулийн чиглэлээр хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн зарим асуудлыг тодруулах зорилгоор ОХУ, БНКУ-ыг сонгож авч тус орнуудын онцлог хуулийн орчуулгыг хийлээ.

Америкийн дээд боловсролд сүүлийн жилүүдэд хамтын удирдлагын өөр нэг хэлбэр болох эрх ашгийн зохистой тэнцвэрийг ханган хамтран удирдах хэв загварыг өргөн хэрэглэж байна. Их сургуулийн удирдах удирдах зөвлөлд гаднын төлөөллийг илүү олноор оролцуулах, их сургуулийн засаглалд их сургуулийн доторх гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийг бэхжүүлэх гэсэн хоёр өөрчлөлт ажиглагдаж байна. Энэ мэт зөвхөн Америкийн төдийгүй баруун Европ, зүүн Азийн их сургуулиудын хөгжлийн сонгодог жишээнүүд олон бөгөөд урьд социалист лагерийн улс гэж нэрлэгдэж байсан улс орнуудад ч нийтийн их сургуулийн засаглал руу бодит алхмыг хийгээд эхэлсэн байна.

Нийтийн их сургуулийг бий болгон хөгжүүлэх нэг арга бол бие даасан их сургуулийн тухай хуулийг батлуулан хэрэгжүүлэх явдал юм. АНУ-д муж улсын үндсэн хуулиудаар их сургуулийн статусыг хуульчлан тодорхойлж, итгэмжлэгчдийн, мөн захирагчдын болон зөвлөлдөх зөвлөлийг байгуулах, томилох асуудлыг нарийвчлан зохицуулсан жишиг байна. Баруун Европын зарим улс орнуудад, тухайлбал Австри Улсад 2002 оны “Их сургуулиудын тухай хууль”, Япон Улсад 2016 оны “Их сургуулийн тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байна<sup>10</sup>.

ОХУ-д мөн “Их сургуулиудын тухай” холбооны хуулийг 2009 онд батлан хэрэгжүүлж байна. Уг хуулиар холбооны их сургууль нь итгэмжлэгчдийн зөвлөл, ерөнхийлөгчтэй байх, төсвийн бус орлогыг өөрийн үзэмжээр захиран зарцуулах, өөрийн стандартад нийцүүлэн бие даан хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг өргөн боломжийг олгож байгаагаараа онцлог юм. Дээрх хуульд мөн дээд боловсролын байгууллагад судалгааны их сургуулийн статус олгох эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Шинжлэх ухаан, технологи, техник, эдийн засаг, нийгмийн салбарыг хүний нөөцөөр хангах, үйлдвэрлэлд өндөр технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн их сургуулийн хөгжлийн хөтөлбөрт сонгон шалгаруулалт хийж 10 жилийн хугацаагаар “судалгааны их сургууль” хэмээх статусыг Засгийн газар олгохоор зохицуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар 50 гаруй их сургууль ийм статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

---

<sup>10</sup> Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл.

Их сургуулийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулах боломж, жишиг байгаа эсэхийг судлан ОХУ-ын нийслэл Москва хот, Санкт-Петербург хотод байрлах нэр бүхий сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрх зүйн байдал нь “М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн” тухай Холбооны хуулиар зохицуулагддаг<sup>11</sup>. Тухайн хуулийн 1 дүгээр зүйлд энэхүү хуулиар Оросын Холбооны Улсын тэргүүлэх, сонгодог сургуулиуд болох М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрх зүйн байдлыг тодорхойлно гэж заасан байдаг. Гэхдээ эдгээр их сургуулиуд нь 200-290 жилийн өмнө үүсгэн байгуулагдсан арвин туршлагатай өөрийн гэсэн судалгааны чиглэл тогтсон сургуулиуд болохыг онцлох нь зүйтэй.

Орчин үеийн сургуулиуд дунд ч мөн өөрийн гэсэн салбар хуультай сургуулиуд ч байдаг байна. Үүний тод жишээ нь Бүгд Найрамдах Казахстан улс юм. Эрх зүйн тогтолцооны хувьд хурдацтай хөгжиж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд ч их сургуулийн эрх зүйн статусыг тодорхойлсон хуультай болох асуудалд анхаарч “Назарбаевын их сургууль”-ийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Бүгд Найрамдах Казахстан Улсын “Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургуулиуд, Назарбаев сан”-гийн тухай хуулийг 2010 онд баталсан байдаг<sup>12</sup>.

Эдийн засгийн хувьд хөгжингүй улсуудад ч тусгайлсан их сургуульд зориулсан хуулиуд баталдаг жишиг байна. Жишээлбэл, Өмнөд Солонгос Улсад “Сөүлийн үндэсний их сургуулийн тухай” хууль (2014), “Улсаны шинжлэх ухаан, технологийн үндэсний институтын тухай” хууль (2013), ХБНГУ-д “Шпэрийн захиргааны шинжлэх ухааны их сургуулийн тухай” Райнланд-Пфальц мужийн хууль (2010), гэх мэт.

Эдгээр нь тухайн улс орнуудад нийтийн их сургуулийг бий болгон хөгжүүлэх анхны алхам, их сургуулиудын статусыг тогтоохын тулд тусгайлсан хуулийг тухайн улсын хууль тогтоох дээд байгууллага батлан мөрдүүлж байгаа гол үндэслэл нь дээрх сургуулиудын өвөрмөц байдал, их сургуулийн бие даасан байдлыг хангах, түүний өвөрмөц тогтолцоо, уламжлал, үнэт зүйл, профессор багш, тэргүүлэх эрдэмтдийн үйл ажиллагааг улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг хүчин зүйлээс хамгаалах гол дархлаа болж байгаагаараа онцлог байна гэж дүгнэх боломжтой.

Орчин үеийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлага “шинэ эдийн засаг” буюу “мэдлэгт суурилсан эдийн засаг”-ийн хөгжлөөр тодорхойлогдох болж, аливаа улс орны нийгэм эдийн засагт шинжлэх ухаан технологи, инновацийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Байгалийн нөөц баялгаас илүү мэдлэг, оюуны чадамж

---

<sup>11</sup> Оросын Холбооны Улсын М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн тухай холбооны хууль // <https://rg.ru/2009/11/13/universitety-dok.html>

<sup>12</sup> Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургуулиуд болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай БНКУ-ын хууль // [https://online.zakon.kz/Document/?doc\\_id=30914968#pos=1;-65](https://online.zakon.kz/Document/?doc_id=30914968#pos=1;-65)

үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нэг чухал эх сурвалж боллоо. Улс оронд мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх гол тулгуур механизм болох үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлэхэд дээд боловсролын салбар, тэр дундаа их сургуулиуд, ялангуяа судалгааны их сургуулиуд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх хандлага зонхилж байна.

### **Долоо. Зөвлөмж**

1. Их сургуулийн хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөнөөр сургалтын хөтөлбөрийн индексэд өөрчлөлт орж үл ойлголцол үүсэх магадлалтай.

Жишээ нь 2012 онд Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчилснөөр “Цагдаа-хууль сахиулах ажил”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” гэх сургалтын хөтөлбөрүүдийг батлуулсан байдаг. Мэдээж үзэл бодлын хувьд цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх нь зөв юм. Гэтэл шилжилтийн хөтөлбөр гэж нэрлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж судлах ёстой байсан хичээлээ судалдаггүй, эсхүл бүрэн хамрагдаж чаддаггүй г.м. Түүнчлэн, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” мэргэжлээр төгссөн төгсөгчид бусад их дээд сургууль, гадаадын их дээд сургуулийн магистрантурт элсэн суралцах боломжгүй бөгөөд хууль сахиулах гэх мэргэжил нь тухайн сургуулиудын тавигдах шаардлагад тохирдоггүй байдал ажиглагдсаар байна. Гадаад оронд ийм жишиг байгаа эсэхийг судлан үзвэл ОХУ-ын ДХЯ-ны сургуулийн төгсөгчид “Правоохранительная деятельность” буюу “хууль сахиулах” гэх мэргэшлээр төгсдөг хэдий ч үндсэн мэргэжлийн чиглэл нь эрх зүй байдаг онцлогтой байна.

Иймд хуульд Их сургуулийн хуулийн этгээдийн нэрийг хуульд тусгаж өгөх шаардлагатай.

Сургуулийн нэр өөрчлөгдөх бүрд сургуулийн билэг тэмдэг, гадна талбайд байрлуулах нэр, албан бланк, сонсогч, суралцагчдын дүрэмт хувцасны таних тэмдэг, алба хаагчдын үнэмлэх зэргийг өөрчлөх шаардлага гардаг нь жилийн төсөвт суугаагүй тооцоолоогүй зардлыг гаргаж, санхүү эдийн засгийн асуудал үүсгэдэг. Түүнчлэн Төсвийн тухай хууль тогтоомжоор тухайн жилийн төсөв хуулиар батлагдах үед хуулийн этгээдийн нэрээр батлагдсан байдаг бөгөөд хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн үед төсвийн мөнгийг зарцуулахад хүндрэл үүсдэг.

Ард иргэдийн дунд төөрөгдөл үүсэхээс гадна чухам аль сургуулийг нэрлээд байгаад төдийлөн ойлголт байдаггүй. Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль гэсэн нэрээр ойлгож байдаг. Мөн шинээр элсэгчдийн хувьд элсэх сургуулийн нэр, сургалтын хөтөлбөрийн индекс жил бүр өөрчлөгдсөнөөр төөрөгдөл үүсдэг. Их сургуулийн нэршлийн хувьд сонирхолтой баримт сонирхуулахад 2009 онд элсэгчид суралцах хугацаандаа 3 сургуульд суралцсан байдаг. Тухайн үед тус сургуульд элсэхдээ Цагдаагийн академид, суралцах хугацаандаа Дотоод хэргийн их сургуульд харин төгсөхдөө Хууль сахиулахын их сургуулийг төгссөн байх жишээтэй.

2. Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг хэт ойр ойрхон өөрчлөх нь давуу талтай гэхээсээ илүүтэйгээр сул тал ихтэй, их сургуулийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх, бодлогын хэрэгжилтэд гажуудал гарах, бэлтгэж буй хүний нөөцийн мэдлэг чадварт сөргөөр нөлөөлөх, багшийн ажлын ачаалал, механик ажилбар ихсэх, алба хаагч, багш судлаачдын ажилдаа хандах хандлага, идэвх сулрах нөхцөл үүсдэг гэж үзэж байна.

3. Дотоод хэргийн их сургуулийн дүрмийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Их сургуулийн багш, ажилтан нар нь төрийн тусгай алба хаагч байна” гэж заасан хэдий ч бусад төрийн тусгай байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаатай харилцан адилгүй байна.

4. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуулийн статусыг тодорхой болгож, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох.

5. Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хуулийн төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

Тус хуулиар дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.  
Үүнд:

- Дээд боловсролын салбарын үйл ажиллагааг зохицуулсан бусад хуультай уялдуулах, зүйл заалтуудтай нийцүүлэх;

- Хуулийн этгээдийн нэрийн тусгаж өгөх;

- Их сургуулийн захирлыг сонгон шалгаруулах, томилох, бүрэн эрхийн хугацааг тодорхой тусгаж өгөх;

- Их сургуулийн захирлын цол болон бусад эрхүүдийг тусгах;

- Их сургуулийн эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх зохицуулалтыг тодотгох;

- Тэтгэлгийн сангийн зохицуулалтыг бий болгох;

- Их сургуулийн Эрдмийн зөвлөлөөс суралцагч нарт тэтгэлэг, хөнгөлөлт олгох зохицуулалтыг бий болгох;

- Бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудын эрхийг тодотгох;

- Их сургуулийн цэргийн цол хэрэглэж байгаа багш, алба хаагчид төрийн тусгай алба хаагч байна гэдгийг хуульчилж тэдний эрх зүйн, нийгмийн, эдийн засгийн баталгааг тодорхой тусгах;

- Санхүүтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан оруулах.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, ГАРЫН АВЛАГА,  
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

**Хууль тогтоомжийн жагсаалт**

1. Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. № 1.
2. Хууль тогтоомжийн тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015.  
№ 25.
3. Боловсролын тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 19.
4. Дээд боловсролын тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 19.
5. Төрийн албаны тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. № 01.
6. Монгол Улсын засгийн газрын тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1993.  
№ 3.
7. Төсвийн тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2012. № 03.
8. Цагдаагийн албаны тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 8.
9. Монгол Улсын хилийн тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. № 6.
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017.  
№ 24.
11. Гамшгаас хамгаалах тухай // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 7.
12. “Оросын Холбооны Улсын М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн тухай” холбооны хууль /орчуулга/.
13. “Назарбаев их сургууль, Назарбаев оюуны өмчийн сургуулиуд болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай” Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль /орчуулга/.
14. Цагдаагийн алба хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/6292?lawid=9876>
15. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/6661?lawid=10935>
16. “Боловсрол” үндэсний хөтөлбөр /2010-2021/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/2599?lawid=5436>
17. Дээд боловсролын зураглал /Roadmap/ 2010-2021. / Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас // URL: <https://mecss.gov.mn/page/41/>

18. Цагдаагийн академи байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2000.02.02. №17. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/law/details/5513?lawid=5513>

19. Дотоод хэргийн их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2011.08.17. №243. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/law/details/2373?lawid=2373>

20. Дотоод хэргийн их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2012.10.13. №87. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763>

21. Хууль сахиулахын их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2015.06.15. №240. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/law/details/11597?lawid=11597>

22. Хууль сахиулахын их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2019.04.17. №152. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/law/details/14309?lawid=14309>

23. Цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдлийн хувь хэмжээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2014.03.28. №99. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/6293?lawid=9876>

24. Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 1999.03.03. №38. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем // URL: <https://www.legalinfo.mn/annex/details/1470?lawid=5537>

#### **Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, илтгэл, өгүүлэл:**

1. Дотоод хэргийн сургуулийн үйл ажиллагааны тайлан 2017, 2018, 2019 он.

2. Батболд Б. Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага // Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. 2019. №03 (30). 13-21 тал.

3. Бат-Эрдэнэ Б. ДХИС-ийн 85 жилийн түүхэн замнал, ололт амжилт // Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2019. 6-11 тал.

4. Бат-Эрдэнэ Б., Эрдэнэбулган Ж. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл // “Тогтвортой хөгжил-дээд боловсрол” зөвлөгөөн.

## ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.1 Ялгаварлан гадуурхахыг хориглох	<b>Тийм</b>	Үгүй	Алба хаагчдын нэмэгдэл, суралцагчдын элсэн суралцах, тэтгэлэгт хамрагдах тэгш байхаар хуульчилна.
	1.1.2 Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Тэтгэлэг олгох суралцагч нарт шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3 Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Алба хаагчдын эрх зүйн байдал баталгаажна.
<b>а. Оролцоог хангах</b>				
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Их сургуулийн алба хаагч, ажилчид болон суралцагчдаас ирүүлсэн саналыг үндэслэж хуулийн төслийг боловсруулна
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хуулийн төслийг боловсруулах явцад бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцно.

<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон хүний эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэлбэрийг хуульчилж болно.
<b>2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх</b>	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь тогтвортой байдал, хариуцлагыг өндөржүүлэх зорилготой.
<b>3. Эрх агуулагч</b>	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	Үгүй	<ul style="list-style-type: none"> <li>• Алба хаагчид</li> <li>• Ажилчид</li> <li>• Суралцагч нар</li> </ul>
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хуулийн төсөлд алба хаагчид, суралцагч нарын эрхийг ялгаж тодорхойлно.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хуулийн төсөлд алба хаагчид, суралцагч нарын эрхийг ялгаж тодорхойлно.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах	<b>Тийм</b>	Үгүй	Хуулийн төсөлд алба хаагчид, суралцагч нарын эрхийг ялгаж тодорхойлно.

	эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			
<b>4. Үүрэг хүлээгч</b>	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Алба хаагчид үйл ажиллагааны чиглэлээр үүрэг хүлээнэ.
<b>5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх</b>	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Жендэрийн тэгш байдлыг тусгах шаардлагагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Баталгаа бүрдэнэ.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Оюутнуудад тэтгэлэг, грант олгохоор бол тодорхой зардал үүсч болно.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Монго Улсын хууль тогтоомжоор хориглоогүй эх

				үүсвэрээс төсөв бүрдэж болох бөгөөд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал</b>	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй,	Нэмэлт зардал үүсэхгүй.
<b>5.Өмчлөх эрх</b>	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Багш, алба хаагчид патент, ашигтай загварын гэрчилгээ авч болно гэх заалт тусгагдаж болно.
<b>6.Инноваци болон судалгаа шинжилгээ</b>	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Судалгаа, шинжилгээ, шинэ бүтээл гаргасан тохиолдолд урамшуулах зохицуулалт орж болно.

	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв</b>	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>8.Тодорхой бүс нутаг, салбарууд</b>	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Салбар сургууль байгуулагдахыг үгүйсгэхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>9.Төрийн захиргааны байгууллага</b>	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Улсын төсөвт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хуулийн дагуу зарим чиг үүрэг нэмэгдэх боловч дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.

<b>10.Макро эдийн засгийн хүрээнд</b>	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>11.Олон улсын харилцаа</b>	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
<b>1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл</b>	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагааны явцад шинээр ажлын байр үүсч болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх</b>	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал</b>	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	үндэстний цөөнхөд гэх мэт			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун</b>	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Дотоод хэргийн их сургуулиас үзүүлэх үйлчилгээ сайжирна
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал</b>	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

<b>6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем</b>	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Бусад их, дээд сургуулиудын их үйл ажиллагаанд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал</b>	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Чадвартай мэргэжилтэн бэлтгэснээр гаралт буурч, эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>8.Соёл</b>	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
<b>1.Агаар</b>	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>2.Зам тээвэр, түлш, эрчим хүч</b>	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>3.Ан амьтан, ургамлыг хамгаалах</b>	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>4.Усны нөөц</b>	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>5.Хөрсний бохирдол</b>	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>6.Газрын ашиглалт</b>	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
<b>7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг</b>	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

**Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны талаарх  
Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудаас түүвэрлэсэн  
судалгаа**

№	Хуулийн нэр	Холбогдох зүйл заалт,
1.	<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ</b>	<p><b>Гучин наймдугаар зүйл.</b> 1.Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.</p> <p><b>Дөчин тавдугаар зүйл.</b> 1.Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.</p> <p><b>Дөчин зургадугаар зүйл.</b> 1.Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна. 2.Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. 3.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно.</p>
2.	<b>БОЛОВСРОЛЫН ТУХАЙ</b>	<p style="text-align: center;"><b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ</b> <b>Нийтлэг үндэслэл</b></p> <p><b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</b> 3.1.5 “сургалтын байгууллага” гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг; 3.1.16 “ашгийн төлөө бус боловсролын байгууллага” гэж сургалтын үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой, үйл ажиллагаанаасаа олсон ашгийг /орлогыг/ зөвхөн үндсэн зорилгын дагуу зарцуулдаг, үндсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаггүй хуулийн этгээдийг;</p> <p><b>7 дугаар зүйл. Боловсролын тогтолцоо</b> 7.1 Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.</p>

## **9 дүгээр зүйл.Боловсролын баримт бичиг**

9.1.Боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшин, мэргэжлийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.

9.2.Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх, диплом/-ийг бүрдүүлэх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

9.3.Ерөнхий боловсролын сургууль, албан бус боловсролын төв нь сургалтын баримт бичиг болох сурагчийн хувийн хэрэг, ангийн журналыг хөтөлнө.

9.4.Сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

9.5.Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ

## **12 дугаар зүйл.Боловсролын байгууллага**

12.1.Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ.

12.2.Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно,:

12.2.1.ашгийн төлөө бус;

12.2.2.ашгийн төлөө.

12.3.Төрийн өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус байна.

12.4.Төрийн бус өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус болон ашгийн төлөө байна.

12.5.Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага байгуулахыг хориглоно.

## **13 дугаар зүйл.Боловсролын байгууллагын тогтолцоо**

		<p>13.1.Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн боловсролын үнэлгээний, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэнэ.</p> <p>13.2.Боловсролын сургалтын байгууллага нь өөрийн үндсэн зорилгодоо нийцсэн судалгаа, туршилт, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл явуулах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн бүтэц бүхий төрөл бүрийн хэв шинжтэй байж болно.</p> <p><b>15 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага</b></p> <p>15.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна.</p> <p><b>19 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллага байгуулах</b></p> <p>19.1.Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, багшлах боловсон хүчнээр хангагдсан нөхцөлд өмчийн аль ч хэлбэрт үндэслэн байгуулж болно.</p> <p>19.2.Боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.</p>
3.	<p><b>ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ</b></p>	<p><b>ГУРАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА</b></p> <p><b>5 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц</b></p> <p>5.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Их сургууль нь профессорын багт тулгуурласан зохион байгуулалтын нэгжтэй байж болно.</p> <p>5.7.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр тодорхой аж</p>

ахуйн нэгж, байгууллагыг сургалт-эрдэм шинжилгээ, дадлагын бааз болгож болно.

5.8.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг их сургууль, дээд сургууль, коллежийн дүрмээр тогтооно.

**6 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, зарим үйл ажиллагааг зогсоох, татан буулгах**

6.1.Дээд боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

6.3.Төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА**

**11 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага**

11.1.Ашгийн төлөө бус төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг тухайн сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

11.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн удирдах зөвлөл нь Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

11.3.Захирал нь энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, томилсон этгээдийн өмнө ажлаа тайлагнана.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

**12.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

12.1.1.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх төрийн бодлого, дээд боловсролын хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд нийцүүлэн сургуулиа хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

		<p>12.1.2.сургалтын агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг сонгож хэрэгжүүлэх;</p> <p>12.1.3.эрдэм шинжилгээ, судалгааны төсөлд оролцох;</p> <p>12.1.4.боловсролын байгууллагын багш, ажилтны цалин хөлсний хэмжээг тогтоох, байгууллагын дотоод журам боловсруулж, мөрдүүлэх;</p> <p>12.1.5.тогтоосон журмын дагуу сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, харьяа нэгж, байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, тэдгээрийн тайлан сонсож үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>12.1.6.суралцагч элсүүлэх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх;</p> <p>12.1.7.багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, тэдний болон төгсөгчийн мэргэшлийг дээшлүүлэх;</p> <p>12.1.11.гадаадын болон дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах.</p> <p>12.3.Дээд боловсролын сургалтын байгууллага Боловсролын тухай хуулийн 39.11-д зааснаас гадна сургалт-судалгааны зориулалт бүхий дараахь нэр төрлийн дэд санг сургууль хөгжүүлэх сангийн дотор байгуулж болно:</p> <p>12.3.1.ажил олгогчдын захиалга, санхүүжилтээр оюутан сургах, сургалт судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих сан;</p> <p>12.3.2.тэтгэлгийн сан;</p> <p>12.3.3.эрсдэлийн сан;</p> <p>12.3.4.хөрөнгө оруулалтын сан;</p> <p>12.3.5.тусгай зориулалттай бусад сан.</p> <p style="text-align: center;"><b>НАЙМДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАТАЛГАА</b></p> <p><b>18 дугаар зүйл. Дээд боловсролын санхүүжилт</b></p> <p>18.1.Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль,</p>
--	--	--

		<p>коллежийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>18.1.1.улсын төсвийн хөрөнгө;</p> <p>18.1.2.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;</p> <p>18.1.3.сургалтын төлбөр;</p> <p>18.1.4.аж ахуйн үйл ажиллагааны орлого;</p> <p>18.1.5.холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу тогтоосон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;</p> <p>18.1.6.зээл, тусламж;</p> <p>18.1.7.бусад эх үүсвэр.</p>
4.	<p><b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ</b></p>	<p style="text-align: center;"><b>ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ</b></p> <p><b>12 дугаар зүйл.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх</b></p> <p>4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоон, тэдгээрийн орон тооны болон зардлын төсвийн хязгаарыг баталж, зохих шатны удирдах ажилтныг томилж, чөлөөлнө.</p> <p><b>18<sup>3</sup> дугаар зүйл.Засгийн газрын агентлаг</b></p> <p>2.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, эрхлэх асуудлынх нь хүрээнд тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Агентлагийг татан буулгасан нь агентлагийн даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Агентлагийн даргыг улируулан томилж болно.</p> <p><b>20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн</b></p> <p>5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:</p>

		<p>7/Хууль зүй, дотоод хэргийн сайд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-эрх зүйн шинэтгэлийн бодлого;</li> <li>-хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;</li> <li>-эрх зүйн туслалцаа;</li> <li>-улсын хил хамгааллын асуудал;</li> <li>-цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;</li> <li>-шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;</li> <li>-Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;</li> <li>-төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;</li> <li>-иргэний харьяалал, цагаачлалын асуудал;</li> <li>-энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;</li> <li>-төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;</li> <li>-иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;</li> <li>-хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;</li> <li>-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;</li> <li>-архивын талаар төрөөс баримтлах бодлого;</li> <li>-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.</li> </ul> <p><b>24 дүгээр зүйл.Засгийн газрын гишүүний бүрэн эрх</b></p> <p>1.Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй. Түүний дотор:</p> <p>4/хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө;</p>
--	--	--

5.	<b>ТӨСВИЙН ТУХАЙ</b>	<p style="text-align: center;"><b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b></p> <p><b>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b></p> <p>4.1.35.“төсвийн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг;</p> <p>4.1.36.“төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;</p> <p>4.1.37.“төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;</p> <p>4.1.38.“төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;</p> <p><b>14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх</b></p> <p>14.1.Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:</p> <p>14.1.8.Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;</p> <p><b>16 дугаар зүйл.Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх</b></p> <p>16.4.Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна:</p> <p>16.4.5.агентлагийн дарга тус агентлагийн төсвийн;</p> <p>16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;</p>
----	----------------------	---

		<p>16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;</p> <p>16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;</p> <p>16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;</p> <p>16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;</p> <p>16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;</p> <p>16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;</p> <p>16.5.8.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх.</p> <p>16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.</p>
6.	<b>ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ</b>	<p><b>7 дугаар зүйл.Төрийн албаны зарчим</b></p> <p>7.1.Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:</p> <p>7.1.1.ард түмэнд үйлчлэх;</p> <p>7.1.2.мэргэшсэн, тогтвортой байх;</p> <p>7.1.3.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;</p> <p>7.1.4.Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;</p> <p>7.1.5.төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;</p>

		<p>7.1.6.ил тод байх;</p> <p>7.1.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</p> <p>7.1.8.захирах, захирагдах ёсыг баримтлах.</p>
--	--	---

**2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн № 259-ФЗ**

**“М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн тухай” холбооны хууль.**

**2009 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Төрийн думаар батлагдсан.**

**2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Холбооны зөвлөлөөр дэмжигдсэн.**

**1 дүгээр зүйл. Энэхүү холбооны хуулиар зохицуулагдах харилцаанууд.**

1. Энэхүү холбооны хуулиар Оросын Холбооны Улсын сонгодог, хосгүй эрдэм шинжилгээ, боловсролын цогцолбор, өөрийн бүтцэд хууль этгээдийн эрхгүй болон эрхтэй нэгжийг багтаасан, ОХУ-ын нийгмийн хөгжилд томоохон учир утга бүхий дээд боловсролын ууган байгууллагууд болох – холбооны, улсын дээд боловсролын байгууллага “М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль” (цаашид М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль) болон холбооны, улсын дээд боловсролын байгууллага “Санкт-Петербургийн улсын их сургууль” (цаашид Санкт-Петербургийн улсын их сургууль) – ын эрх зүйн байдлыг тодорхойлдог.

2. Оросын Холбооны Улсын боловсролын хууль тогтоомжийг М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн хувьд энэхүү холбооны хуульд заасан онцлогуудыг харгалзан үзэж хэрэглэдэг.

**2 дугаар зүйл. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрх зүйн байдал**

1. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулийн үйл ажиллагааг энэхүү хууль болон боловсролын хүрээн дэх Оросын Холбооны Улсын хууль хууль зүйн акт, бусад холбооны хууль, Оросын Холбооны Улсын бусад эрх зүйн баримт бичгүүд мөн М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн дүрмээр тус тус зохицуулна.

2. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулиуд нь холбооны, улсын төрийн өмчит байгууллага мөн.

3. Оросын Холбооны Улсын нэрийн өмнөөс М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль болон Санкт-Петербургийн улсын их сургуулиудын үндэслэгч нь Оросын Холбооны Улсын Засгийн газар байна.

4. Оросын Холбооны Улсын Засгийн газар нь М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн

дүрэм болон тэдгээрт орсон өөрчлөлтүүдийг батална. Үндэслэгчийн бусад эрх хэмжээ нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжинэ.

5. Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч нь М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирлыг тус тус томилж, чөлөөлнө. Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирлыг албан тушаалд томилох хугацаа таван жилээс хэтрэхгүй байна. Үүнээс гадна М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирлыг улиралуулан томилж болно. Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч нь М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирлыг хугацаанаас өмнө албан тушаалаас чөлөөлж болно.

6. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирал нь Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон, дээд боловсролын улсын байгууллагын захирлын албан тушаалыг хаших хязгаар бүхий насанд хүрсэн тохиолдолд Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч нь энэхүү зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаагаар улиралуулан ажиллуулж болно.

### **3 дугаар зүйл. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор.**

1. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборын бүтэц нь М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн дүрмээр тус тус тодорхойлогдоно.

2. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн бүтцийн нэгжид салбар, төлөөлөгчийн газар, факультет болон хууль этгээдийн эрхзүйн бусад бүтцийн нэгжүүд орж болно. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборт тэдгээрийн дүрмийн дагуу хуулийн этгээдүүд тэр дундаа институт, сургуулиуд орж болно.

3. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь салбар болон төлөөлөгчийн газраа нээх эрхтэй бөгөөд гадаадын орнуудад ч нээх боломжтой.

4. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн бүтцийн нэгжүүд, Санкт-Петербургийн улсын их сургуулийн бүтцийн нэгжүүдийн мөн эдгээр сургуулиудын эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборт багтах хуулийн этгээдүүдийн эрх зүйн байдал энэхүү холбооны хууль, бусад холбооны хуулиуд мөн М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн дүрмээр тодорхойлогдоно.

5. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборт багтах хуулийн этгээдүүдийн үндэслэгчийн эрх хэмжээг М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуультай зөвшилцсөний үндсэн дээр Оросын Холбооны Улсын Засгийн газрын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолбор, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборт багтах хуулийн этгээдүүдийн удирдагч нарыг эдгээр их сургуулиудын захирлууд Оросын Холбооны Улсын Засгийн газрын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн томилж, чөлөөлнө.

6. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн факультетын деканууд, тэнхимийн эрхлэгч нарыг эдгээр их сургуулиудын дүрэмд заасан журмын дагуу сонгодог. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн бусад нэгжүүдийн удирдлагуудыг эдгээр их сургуулиудын захирал албан тушаалд томилж, чөлөөлнө.

#### **4 дүгээр зүйл. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн сургалтын үйл ажиллагаа явуулах онцлог.**

1. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг бие даан тогтоосон сургалтын стандартад суурилан явуулна.

1.1 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь өөрийн үндэслэн байгуулсан Оросын Холбооны Улсын бүс нутгаас гадна орших сургалтын байгууллагад дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг бие даан тогтоосон сургалтын стандартад суурилан явуулах эрхтэй. Эдгээр дээд боловсролын сургалтын хөтөлбөрөөр суралцагчдыг элсүүлэх, суралцагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох, заагдсан дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тэр дундаа улирлын нэгдсэн шалгалт авах нь эдгээр сургалтын байгууллагыг үндэслэсэн баримт бичгийн журмын дагуу явагдана.

2 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн бие даан тогтоосон сургалтын стандартад нийцүүлэн гаргасан дээд боловсролын сургалтын үндсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага, хөтөлбөрийг эзэмших үр дүн нь холбооны улсын сургалтын стандартаас доош байж болохгүй.

3 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн Сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэх журмыг Оросын Холбооны Улсын Засгийн газар тогтооно.

4 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь мэргэшлийн чиглэлийн хүрээнд бакалавр, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн элсэлтийн хүрээнд нэмэлт шалгалт авах эрхтэй.

5 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь энэхүү хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийг хангасан, төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн хүмүүст Оросын Холбооны Улсын төрийн сүлдтэй, М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн тамгаар баталгаажуулсан боловсролын болон мэргэшлийн баримт бичгийг олгох бөгөөд эдгээр баримт бичгийн хэлбэрийг тус сургуулиуд тус тус батална.

6 М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулиас олгодог боловсролын болон мэргэшлийн баримт бичиг нь тэдгээрийн өмчлөгчдөд “Оросын Холбооны Улсын боловсролын тухай” холбооны хуулийн дагуу өгөгддөг эрхтэй адил эрхийг олгодог.

### **5 дугаар зүйл. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн санхүүжилт.**

1. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь холбооны төсвөөс болон Оросын Холбооны Улсын хууль тогтоомжоор хориглоогүй эх үүсвэрээс бүрдэнэ.

2. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь улсын захиалгын дагуу тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэй.

3. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн мэдэлд байх сургалтын, үйлдвэрлэлийн, объектууд (барилга, байгууламж), сургалтын, үйлдвэрлэлийн, нийтийн, соёлын, дотуур байр, клиник сургалтын төвийн зориулалттай барилга нь холбооны өмч байх бөгөөд хувьчлах хориотой.

4. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургууль нь түрээсийн гэрээний дагуу эдгээр сургуульд хамаарах байгууламжийг түрээслэх эрхтэй. Байгууламж хэрэгцээтэй иргэдийн төрлийн Оросын Холбооны Улсын Засгийн газраас тогтооно.

### **6 дугаар зүйл. Шилжилтийн зохицуулалт.**

1. Энэхүү хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө томилогдсон М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирал нь энэхүү хуулийн дагуу Оросын Холбооны Улсын ерөнхийлөгчийг дараагийн захирлыг тус тус томилж хүртэл албан үүргээ гүйцэтгэнэ.

2. Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн захирал, Санкт-Петербургийн улсын их сургуулийн захирлыг томилсноос хойш нэг жилийн дотор М.В. Ломоносовын нэрэмжит

Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн дүрмийг энэхүү хуультай нийцүүлэн өөрчилнө.

3. Энэхүү хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургуулийн дүрэм, Санкт-Петербургийн улсын их сургуулийн дүрмийн зөвхөн энэхүү хуультай зөрчилдөөгүй заалтууд л хэрэгжинэ.

4. М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын их сургууль, Санкт-Петербургийн улсын их сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын цогцолборын бүтцэд багтах хуулийн этгээдийн санхүүжилт нь холбооны төсвөөс санхүүжих ба дараа жилийн төсвийн тухай холбооны хууль батлагдах хүртэл санхүүжнэ.

Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч

Д.Медведев

Москва, Кремль  
2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр  
№ 259-ФЗ

**Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургуулиуд болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль.**

**2011 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр. № 394-IV**

**1 дүгээр зүйл. Энэхүү хуульд хэрэглэгдэж байгаа нэр томьёо.**

Энэхүү хуульд дараах нэр томьёонууд хэрэглэгдсэн:

1) бие даасан боловсролын байгууллага - Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газраас байгуулдаг, эрх зүйн байдал, үйл ажиллагааны тусгай эрх зүйн дэглэм нь энэхүү хуулиар тогтоогддог гишүүнчлэлийн эрхгүй ашгийн бус байгууллага;

2) Оюуны сургалтын байгууллага – Оюуны сургуулиудын байгуулдаг ашгийн бус байгууллага, хувьцааны тавь ба түүнээс дээш хувь нь эзэмших болон итгэмжлэн удирдах хэлбэрээр Оюуны сургуулудад харьяалагддаг бусад хуулийн этгээд;

3) “Назарбаев их сургууль” сургалтын грант /тэтгэлэг/ - энэхүү хуулиар тогтоосон сургалтын хэмжээнд нийцсэн эсхүл бэлтгэлийн хэсэгт Их сургуулийн сургалтын төлбөрийн хүрээнд улсын захиалгаар сурах суралцагчид өгөх зорилтот мөнгөний нийлбэр;

4) “Назарбаев их сургууль” тэтгэлэг – “Назарбаев их сургууль” грантын хүрээнд суралцагчид олгогдож байгаа мөнгө;

5) хичээлээс гадуурх үйл ажиллагаа – Их сургуулийн, Оюуны сургуулийн сургалтын үйл ажиллагааны оролцогчдын зүгээс ивээн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр батлагдан арга хэмжээ зохион байгуулах хэлбэрээр явагддаг суралцагчдыг олон талаар хөгжүүлэх, тэдний хувийн чадварыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

6) Их сургуулийн инновацийн багц (цаашид инновацийн багц) – Их сургуулийн бүсэд байрлах эрдэм шинжилгээ, судалгааны болон инновацийн үйл ажиллагааны субъектүүд, мөн тэдэнтэй хамтартарч ажилладаг бараа (ажил, үйлчилгээ) нийлүүлэгчдийн нэгдэл, тэдгээр нь нэг нэгнийхээ дутуу талыг нөхөж, өрсөлдөх чадварыг эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, бүтээн байгуулалт, технолгийг шилжүүлэх, төсөл хэрэгжүүлэх, шинэ технологи бүтээх, нэвтрүүлэх замаар нэмэгдүүлнэ;

7) Их сургуулийн нэгжүүд – Их сургуулийн байгуулдаг ашгийн бус байгууллага, хувьцааны тавь ба түүнээс дээш хувь нь эзэмших болон итгэмжлэн удирдах хэлбэрээр Их сургуульд харьяалагддаг бусад хуулийн этгээд;

**2 дугаар зүйл. Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургууль болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж.**

1. Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургууль болон Назарбаев сангийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Бүгд Найрамдах Казахстан улсын Үндсэн хуульд үндэслэдэг бөгөөд энэхүү хууль болон Бүгд Найрамдах Казахстан улсын бусад эрх зүйн актаас бүрдэнэ.

2. Бүгд Найрамдах Казахстан улсын сургалтын, эрдэм шинжилгээ, эрдэм шинжилгээ технологийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж нь тус Их сургууль, Оюуны сургуулиуд, тэдгээрийн байгууллагууд болон санд энэхүү хуулиар зохицуулагдаагүй харилцааны хүрээнд хэрэглэгддэг.

3. Хэрэв Бүгд Найрамдах Казахстан улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэхүү хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний хэм хэмжээг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл. Назарбаев их сургууль, Назарбаев оюуны сургууль болон сангийн үйл ажиллагааны зарчим**

Их сургууль, Оюуны сургууль болон сангийн үйл ажиллагаа дараах зарчим дээр суурилна:

1. Академик эрх чөлөөний зарчим - Их сургууль болон Оюуны сургуулиудын сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааны хэлбэр, арга зүй, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиглэлийг боловсруулах, сонгох хүрээн дэх бие даасан байдал;

2. Сургалт, эрдэм шинжилгээ болон үйлдвэрлэлийн харилцан уялдаа холбооны зарчим – Их сургууль болон Оюуны сургуулиудад сургалтын процессийн эрдэм шинжилгээ, практик үйл ажиллагаанаас салшгүй байдал, шинжлэх ухаан, бизнесийн байгууллагуудтай стратегийн түвшний түншлэл;

3. Бие даасан байдал болон өөрөө удирдах зарчим - Их сургууль, Оюуны сургууль болон сангийн санхүү, эдийн засаг, захиргааны удирдлага, шийдвэр гаргах ялгавартай, бие даасан байдал;

4. Хамтын шийдвэр гаргах зарчим - Их сургууль, Оюуны сургууль болон сангийн үйл ажиллагаатай холбогдолтой шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл, Дээд төлөөлөн удирдах зөвлөл гаргах;

5. Нийгмийн хариуцлага болон ил тод байдлын зарчим - Их сургууль, Оюуны сургууль болон сангийн зүгээс нийгмийн халамжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөлт хөтөлбөр боловсруулах, оролцох, өөрийн үйл ажиллагааны бүхий л чиглэлээр мэдээллийн нээлттэй байдлыг хангах.

### **4 дүгээр зүйл. Их сургууль, Оюуны сургууль болон Сангийн эрх зүйн байдал**

1. Их сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулах тэр дундаа нэмэлт сургалт, шинжлэх ухаан, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа явуулах, орчин үеийн сургалтын, шинжлэх ухааны дэд бүтцийг бүрдүүлэх болон дүрмийн дагуу бусад үйл ажиллагааг явуулахаар байгуулагдсан бие даасан сургалтын байгууллага юм.

Их сургууль нь дараах түвшний сургалтыг зохион байгуулна:

- 1) Бүрэн дунд боловсролын дараах;
- 2) Дээд боловсролын;
- 3) Их сургуулийн дараах боловсролын.

Их сургууль нь боловсрол, шинжлэх ухааны салбарт мониторинг, судалгаа, шинжилгээ, инновацийн хөтөлбөр боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтын талбар юм.

2. Оюуны сургуулиуд нь сургалтын үйл ажиллагаа, тэр дундаа нэмэлт боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан бие даасан сургалтын байгууллага юм.

Оюуны сургуулиуд нь дараах түвшний сургалтыг зохион байгуулна:

- 1) Бага сургууль, сургуулийн өмнө боловсрол олгох;
- 2) Ерөнхий сургууль;
- 3) Ахлах сургууль.

Оюуны сургуулиуд нь дүрэмд нийцсэн бусад үйл ажиллагааг явуулах эрхтэй.

Оюуны сургуулиуд нь мониторинг, судалгаа, шинжилгээ, орчин үеийн сургалтын хөтөлбөрийн загвар, технологи боловсруулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтын талбар юм.

3. Их сургууль болон Оюуны сургуулиудын үндэслэгч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар байна.

4. Сан нь Их сургууль болон Оюуны сургуулиудын, тэдгээрийн бүтцийн нэгжийн санхүүжилтийг хангах чиг үүрэг бүхий ашгийн бус байгууллага юм.

### **5 дугаар зүйл Их сургууль болон Оюуны сургуулиудын эд хөрөнгө**

1. Их сургууль болон Оюуны сургуулиудын эд хөрөнгө нь дараах зүйлээс бүрдэнэ:

- 1) Үүсгэн байгуулагчийн зорилтод хөрөнгө оруулалт;
- 2) Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газрын шийдвэрээр шилжүүлсэн улсын эд хөрөнгө;
- 3) Сайн дурын хандив, өглөг;
- 4) Сангаас оруулсан санхүүжилт;
- 5) Бүгд Найрамдах Казахстан улсын хууль тогтоомжоор тогтоосон ажил, үйлчилгээг хэрэгжүүлсний төлбөр;
- 6) Ногдол ашиг, (орлого, үнэт цаас, хадгаламжийн урамшуулал, хүү);
- 7) Бүгд Найрамдах Казахстан улсын хуулиар хориглоогүй эх үүсвэрээс.

Энэхүү заалтын хүрээнд цугларсан Их сургууль болон Оюуны сургуулиудын эд хөрөнгө нь тэдэнд өмчлөх эрхийн хүрээнд хадгалагдана.

Их сургууль болон Оюуны сургуулиуд нь өөрсдийн эд хөрөнгийг үүсгэн байгуулагдсан зорилгодоо хүрэх зорилгоор ашиглана.

2. Их сургууль болон Оюуны сургуулиуд болон тэдгээрийн бүтцийн нэгжүүд нь Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу улсын даалгавар, улсын сургалтын захиалга, баталсан хэмжээгээр эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх улсын захиалга хүлээн авах эрхтэй.

2-1. Бие даасан байгууллага дараах эрхтэй:

1) Дээд удирдлага эсхүл Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүнээс өгсөн даалгаврын дагуу зорилтод төсвийн хөрөнгийг хуваарилах;

2) Урсгал зардал, эсхүл түүнд хамаарахгүй зардлаас хэмнэсэн зорилтод төсвийн хөрөнгийг сургалтын бие даасан байгууллагыг хөгжүүлэх зорилгоор тус бүрд нь хуваарилах;

Төсвийн жилийн хугацаанд зарцуулагдаагүй үлдсэн зорилтод төсвийг сургалтын бие даасан байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу дараагийн оны төсөвт шилжүүлж болно.

2-2 Энэхүү зүйлийн 2-р дэд хэсэг, 1-р хэсэгт заасны дагуу улсын өмч, хөрөнгийг сургалтын бие даасан байгууллагад шилжүүлэхдээ Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу буцаан авахгүй байх үндсэн дээр шилжүүлнэ. Улсын өмчид хамаарах газрын хэсэг нь Их сургуульд Бүгд Найрамдах Казахстан Улсын Газрын тухай хуулийн дагуу буцаан авахгүй байх үндсэн дээр олгогдоно.

3. Үндэслэгч нь сургалтын бие даасан байгууллагын өмчийг өмчлөх эрхийг эдлэхгүй.

Үндэслэгч нь сургалтын бие даасан байгууллагын үүсгэсэн төлбөр төлөх үүрэгт хариуцлага хүлээхгүй ба сургалтын байгууллага мөн адил үүсгэн байгуулагчийхад хүлээхгүй.

**6 дугаар зүйл. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн удирдах нэгжүүд.**

1. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн дээд удирдах нэгж нь Дээд төлөөлөн удирдах зөвлөл байна.

Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн Нэгдүгээр тэргүүлэгч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын ерөнхийлөгч – Елбасы Нурсултан Абишевич Назарбаев байна.

Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүн батална.

2. Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, эрх хэмжээ, бүрэлдэх журам, зөвлөлийн гишүүдийн ажиллах хугацаа, шийдвэр гаргах журам нь энэхүү хууль болон Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн тухай журмаар зохицуулагдана.

3. Дээд удирдах зөвлөлийн эрх хэмжээнд дараах зүйл хамаарна:

- 1) Их сургууль, Оюуны сургуулиудын болон Сангийн хөгжлийн урт хугацааны стратеги;
- 2) Эд хөрөнгийг захиран зарцуулах журмыг батлах;
- 3) Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах;
- 4) Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх;
- 5) Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн бүтцийг өөрчлөх, татан буулгах шийдвэрийг гаргах;
- 6) Дээд төлөөлөн удирдах зөвлөлийн журмын дагуу бусад эрх хэмжээнүүд;

4. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн үйл ажиллагааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий байгууллага нь байнгын үйл ажиллагаагаа явуулдаг төлөөлөн удирдах зөвлөлүүд байна;

Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн төлөөлөн удирдах зөвлөлүүдийн бүтэц, эрх хэмжээ, бүрэлдүүлэх журам, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, шийдвэр гаргах журам нь энэхүү хууль болон эдгээр байгууллагуудын дүрмээр тодорхойлогдоно.

5. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ:

- 1) Жилийн болон дунд хугацааны төсвийг батлах;
- 2) Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн гүйцэтгэх нэгжийн тоо, тэдгээрийн удирдагч, гишүүд эсхүл бие даан гүйцэх нэгжийн үүргийг гүйцэтгэдэг хүнийг сонгох, хугацаанаас өмнө албан тушаалаас чөлөөлөх;
- 3) Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах журмыг батлах;
- 4) Энэхүү хууль болон Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомж, Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн дүрэмд заасан эрх хэмжээнүүд.

6. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үндэслэгчийн төлөөлөл, эрдэм шинжилгээ, боловсролын ажилтнууд, төрийн бус байгууллагын төлөөлөл болон бусад хүмүүс багтана. Эдгээр байгууллагуудын удирдах нэгжид төрийн албан хаагчид томилогдсон тохиолдолд Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн удирдах ажилд оролцож болно.

7. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлагыг гүйцэтгэх нэгж хэрэгжүүлэх бөгөөд гүйцэтгэх нэгж нь хамтарсан багийн болон нэг бие хүнтэй байж болно.

Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн гүйцэтгэх нэгжүүд нь Дээд төлөөлөн удирдах зөвлөл, Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх зарчмаар ажиллана.

Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн гүйцэтгэх нэгжийн бүтэц, эрх хэмжээ, бүрэлдэх журам, бүрэн эрхийн хугацаа эдгээр байгууллагуудын дүрмээр тогтоогдоно.

8. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн хүрээнд эдгээр байгууллагын дүрмийн дагуу бусад байгууллагууд байгуулагдаж болно.

**7 дугаар зүйл. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн бүтцийг өөрчлөх, татан буулгах.**

1. Энэхүү хууль, Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомж, Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн дүрмийн дагуу эдгээр байгууллагуудын бүтцийг өөрчилж, татан буулгаж болно.

2. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Санг татан буулгасан тохиолдолд төлбөр авагчийн төлбөрийг барагдуулсны дараагаар үлдсэн эд хөрөнгийг үндэслэсэн баримт бичигт заасан зорилтод хүргүүлнэ.

**8 дугаар зүйл. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн үйл ажиллагааны зөвшөөрөл, аттестатчлах, магадлан итгэмжлүүлэх.**

1. Их сургууль, Оюуны сургуулиуд, тэдгээрийн бүтцийн нэгжүүд мөн Их сургууль, Оюуны сургуулиудад өөрийн хөтөлбөрийг нэвтрүүлж байгаа, хэрэгжүүлж байгаа гадаадын хуулийн этгээдүүд тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.

2. Бүгд Найрамдах Казахстан Улсын боловсролын тухай хуульд заасан улсын аттестчлал Их сургууль, Оюуны сургуулиудад явагдахгүй.

3. Их сургууль, Оюуны сургуулиудын магадлан итгэмжлэл нь төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу үндэсний болон гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагуудаар явуулна.

**9 дүгээр зүйл. Их сургуулийн сургалтын үйл ажиллагаа явуулах онцлог.**

1. Их сургууль, түүний бүрэлдэхүүн нэгжүүд нь өөрийн бие даан боловсруулсан сургалтын хөтөлбөр болон гадаадын хамтран ажилладаг түншийн сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаагаа явуулна.

Их сургууль нь хичээлээс гадуурх үйл ажиллагааны чиглэл, жагсаалтыг бие даан тодорхойлно.

Их сургууль дахь хүмүүжлийн ажлыг Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан хүмүүжлийн ажил, казах үндэсний эх оронч үзлийг бүрдүүлэх хэтийн хөтөлбөртэй нийцүүлэн явуулна.

2. Сургалтын үйл ажиллагааг явуулах, сургалтын чанар, мониторинг, элсэлт, сурлагын амжилтын хяналт, суралцагчдын улирлын болон төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах журмыг дүрэмд нийцүүлэн Их сургууль болон бүтцийн нэгжүүд тодорхойлно.

3. Их сургууль, бүтцийн нэгжүүд нь сургалтын үйлчилгээ үзүүлэх гэрээг бие даан байгуулна.

4. Сургалтын үйл ажиллагаа явуулдаг Их сургуулийн байгууллага нь тэдний хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийг хангасан, төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн хүнд боловсролын болон (эсхүл) мэргэшлийн баримт бичгийг олгоно. Боловсролын баримт бичгийн хэлбэр, бөглөх журмыг байгууллагууд бие даан батална.

5. Их сургууль нь тэнд хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийг хангасан, төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн хүнд боловсролын болон (эсхүл) мэргэшлийн баримт бичгийг олгоно. Боловсролын баримт бичгийн нэгдсэн хэлбэр, бөглөх журмыг Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

6. Их сургууль, түүний бүтцийн нэгжүүдээс олгогдож байгаа боловсролын болон (эсхүл) мэргэшлийн баримт бичиг нь баримт бичиг эзэмшигчдэд боловсролын улсын хэлбэрийн баримт бичиг эзэмшигчтэй адил эрхийг олгоно.

### **10 дугаар зүйл. Оюуны сургуулиудын сургалтын үйл ажиллагаа явуулах онцлог.**

1. Оюуны сургуулиуд нь өөрийн бие даан боловсруулсан сургалтын хөтөлбөр болон гадаадын хамтран ажилладаг түншийн сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаагаа явуулна.

Оюуны их сургуулиуд дахь сургалтын хөтөлбөрүүд нь энэхүү хуулиар тогтоосон боловсролын түвшний хүрээнд явагдана.

Оюуны сургуулиуд нь хичээлээс гадуурх үйл ажиллагааны чиглэл, жагсаалтыг бие даан тодорхойлно.

Оюуны сургуулиуд дахь хүмүүжлийн ажлыг Оюуны сургуулиудын төлөөлөн удирдах зөвлөлүүдийн тус тус баталсан хүмүүжлийн ажил, казах үндэсний эх оронч үзлийг бүрдүүлэх хэтийн хөтөлбөртэй нийцүүлэн явуулна.

2. Оюуны сургуулиуд нь бие даан дараах журмыг батална:

- 1) Суралцагчдыг элсүүлэх;
- 2) Сургалтын үйл ажиллагаа, тэр дундаа хичээлээс гадуурх арга хэмжээний;
- 3) Туршилтын үйл ажиллагааны;
- 4) Суралцагчдын сурлагын амжилт, улирлын болон төгсөлтийн шалгалтад хяналт тавих;
- 5) Суралцагчдын гаргасан сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ хийх;
- 6) Сургалт, сургалтын чанарт мониторинг хийх;
- 7) Ажилчдын мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлэх;
- 8) Багшлах бүрэлдэхүүнийг аттестатчилах, аттестатчилал зохион байгуулах давтамжийг тодорхойлох.

Оюуны сургуулиудад сургалтын чанарын Оюуны сургуулиудын бие даан тогтоосон журмын дагуу зохицуулна.

3. Бүгд Найрамдах Казахстан Улсын 2016.04.09-ний өдрийн № 501-V дугаар тушаалаар хүчингүй болсон.

4. Оюуны сургуулиуд нь тэнд хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийг хангасан, төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн хүнд боловсролын баримт бичгийг олгох бөгөөд энэхүү баримт бичиг нь улсын боловсролын баримт бичигтэй адил хүчинтэй. Боловсролын баримт бичгийн нэгдсэн хэлбэр, бөглөх журмыг Оюуны сургуулиудын төлөөлөн удирдах зөвлөлүүд тус тус батална.

5. Бүгд Найрамдах Казахстан Улсын 2016.04.09-ний өдрийн № 501-V дугаар тушаалаар хүчингүй болсон.

### **11 дүгээр зүйл. Их сургууль нь шинжлэх ухаан болон (эсхүл) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа явуулах нь**

1. Их сургууль нь шинжлэх ухаан болон (эсхүл) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг грант, зорилтот хөтөлбөрийн санхүүжилт болон Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжоор хориглоогүй эх үүсвэрээс бүрдсэн санхүүжилтээр явуулна.

2. Их сургууль нь салбарын эрдэм шинжилгээний төвийг байгуулах эрхтэй.

3. Их сургууль болон түүний салбарын эрдэм шинжилгээний төвүүд нь Бүгд Найрамдах Казахстан шинжлэх ухааны тухай хууль тогтоомжид заасан шинжлэх ухаан (эсхүл) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны магадлан итгэмжлэлээс чөлөөлөгдөнө.

4. Их сургууль нь шинжлэх ухаан (эсхүл) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнг практикт хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй.

Их сургууль, түүний салбарын эрдэм шинжилгээний төвүүдийн шинжлэх ухаан (эсхүл) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнг практикт хэрэгжүүлснээс олсон орлогыг зөвхөн Их сургууль, түүний салбарын эрдэм шинжилгээний төвүүдийг хөгжүүлэхэд зарцуулна.

### **12 дугаар зүйл. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Санд гадаадын ажиллах хүчийг урих онцлог**

1. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Санд гадаадын дээд боловсролтой ажиллах хүчийг урьж удирдах албан тушаал, мэргэжилтнээр ажиллуулахад гадаадын ажиллах хүчийг ажиллуулах зөвшөөрөл шаардахгүй.

2. Их сургууль эсхүл түүний эмнэлгийн албанд урьж ажиллуулах хүний гадаадын улсад авсан эмнэлгийн үйлчилгээ эрхлэх эсхүл мэргэшлийн зэргийг нотолсон баримт бичиг нь Бүгд Найрамдах Казахстан улсын нутаг дэвсгэрт үйлчилж байгаа мэргэжилтний сертификаттай адил хүчинтэй.

### **12-1 дүгээр зүйл. Их сургууль болон Оюуны сургуулиудын тэтгэлэг, ТЭТГЭМЖ**

1. Суралцагч Их сургуульд “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлэг, Бүгд Найрамдах Казахстан Улсын анхны ерөнхийлөгч Елбасы сургалтын олон улсын тэтгэлэг, бусад тэтгэлэг, тэтгэмж болон төлбөрийн үндсэн дээр суралцана.

“Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлэг нь Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэд, харьяалалгүй, Бүгд Найрамдах Казахстан Улсад байнгын оршин суудаг этгээдүүдэд болон Бүгд Найрамдах Казахстан Улсын олон улсын гэрээний дагуу гадаадын иргэдэд олгогддог.

Бүгд Найрамдах Казахстан Улсын анхны ерөнхийлөгч Елбасы сургалтын олон улсын тэтгэлгийг Бүгд Найрамдах Казахстан Улсын ерөнхийлөгч баталдаг бөгөөд Их сургуульд суралцахаар элссэн энэхүү зүйлийн 2 дугаар хэсэгт заасанд хамаарахгүй гадаадын иргэд, харьяалалгүй этгээдүүдэд олгогддог.

2. “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгээр суралцах эрх нь үүссэн гадаадын иргэд, харьяалалгүй этгээдүүдийн квотыг батлагдсан улсын сургалтын захиалгын хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газраас тодорхойлно.

3. Их сургуулийн дүрэм, дотоод баримт бичгийн дагуу Их сургууль нь бие даан суралцагчдад “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгийг гардуулна.

4. Их сургууль нь бие даан “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгийн төсвийг зорилтот байдлаар гардуулах, буцаан авах эсхүл шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

5. “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгийн төсвийг бүрдүүлэхдээ Их сургуулийн сургалтын үйл ажиллагааны зардлыг тооцоолно. “Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлэг төсвийг бүрдүүлэхэд тооцоолсон сургалтын зардал нь Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдана.

“Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгийн төсвийн зардлын хэм хэмжээ нь Их сургуулийн дотоод баримт бичигтэй нийцүүлэн батлагдана. “Назарбаев их сургууль” тэтгэлгийн оноох, олгох журмыг Их сургуулийн дотоод баримт бичигтэй нийцүүлэн тодорхойлно.

“Назарбаев их сургууль” сургалтын тэтгэлгийн хэмжээг Их сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу боловсролын салбарын эрх бүхий байгууллага хянаж үзэх ба Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар батална.

6. Оюуны сургуулиудад гойд авьяастай хүүхдийн сонгон шалгаруулалтын үндсэн дээр Бүгд Найрамдах Казахстан Улсын анхны ерөнхийлөгч Елбасы “Өркен” сургалтын тэтгэлгээр сургалтын төлбөрийг төлнө.

Бүгд Найрамдах Казахстан Улсын анхны ерөнхийлөгч Елбасы “Өркен” сургалтын тэтгэлгийн хэмжээг Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар батална.

Их сургууль болон Оюуны сургуулиуд нь бусад сургалтын тэтгэлэг, тэтгэмж, өөрийн төсвөөс эсхүл Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжоор

хориглоогүй эх үүсвэрээс суралцагчдад олгох нөхөн олговрыг байгуулах эрхтэй. Бусад сургалтын тэтгэлэг, тэтгэмж, тэтгэлэг, нөхөн олговрын хэмжээг Их сургууль болон Оюуны сургуулиуд бие даан тодорхойлно.

### **12-2 дугаар зүйл. Инновацийн багц**

1. Инновацийн багцийн дэд бүтцийн элементүүд:
  - 1) Их сургууль;
  - 2) Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиуд болон эрдэм шинжилгээний төвүүд;
    - 3) Эрдэм шинжилгээ эрхэлсэн төв байр;
    - 4) Арилжааны байр;
    - 5) Туршилтын цех;
    - 6) Гэрээний судалгааны төв;
    - 7) Бизнесийн инкубатор;
    - 8) Шинжлэх ухааны парк;
    - 9) Технологийн парк.
2. Инновацийн багцийн оролцогч нар дараах зэрэглэлүүдийн нэгийг олгоно:
  - 1) Шинийг санаачлагч;
  - 2) Шинэлэг компани;
  - 3) Өндөр технологийн компани;
  - 4) Судалгааны төв.
3. “Шинийг санаачлагч” зэрэглэл нь дараах нөхцөлөөр олгоно:
  - 1) Хүсэлт гаргагч нь хувь хүн байх;
  - 2) Хүсэлт гаргагч нь эрдэм шинжилгээ, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа болон (эсхүл) туршилт, угсралтын ажил хийдэг, арилжааны байр, туршилтын цехийн суурин дээр судалгааны, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа болон (эсхүл) туршилт, угсралтын ажлын үр дүнг борлуулах ажлын оролцогч байх;
  - 3) Хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээний судалгаа, бүтээлийн үр дүн болсон технологи, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бүтээх эсхүл урагшлуулах, боловсронгуй болгох, технологийг шилжүүлэхтэй холбоотой байна.
5. “Өндөр технологийн компани” зэрэглэл хүсэлт гаргагчид дараах нөхцөлөөр олгогдоно:
  - 1) Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд байна;
  - 2) Хүсэлт гаргагч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газрын баталсан жагсаалт бүхий өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг шинжлэх ухааны паркийн оролцогч байна.
6. “Судалгааны төв” зэрэглэл нь хүсэлт гаргагчид дараах нөхцөлөөр олгогдоно:

1) Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд эсхүл салбар, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар;

2) Хүсэлт гаргагч нь шинжлэх ухааны паркийн оролцогч бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны болон туршилт, угсралтын үйл ажиллагаа явуулдаг.

7. Инновацийн багцийн сонгон шалгаруулалт, оролцогчид зэрэглэл олгох хураан авах, инновацийн багцийн үйл ажиллагааны журмыг Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

8. Их сургууль, түүний бүтцийн байгууллагуудаас Инновацийн багцийн оролцогч нарыг дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан журмын дагуу явуулна.

Их сургууль, түүний бүтцийн байгууллагуудаас Инновацийн багцийн оролцогч нарыг дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд дараах зүйлс хамаарна:

1) Санхүүжилт тэр дундаа хамтран санхүүжүүлэх, урьдчилан лизингийн хэлбэрээр санхүүжүүлэх, инновацийн багцийн оролцогчдын грантын тэтгэлгээр санхүүжүүлэх;

2) Инновацийн багцийн оролцогч нарт хөрөнгө оруулалт татах;

3) Инновацийн багцийн оролцогч нарыг мэргэшсэн хүний нөөцөөр хангах;

4) Инновацийн багцийн оролцогч нарт шинжлэх ухааны төсөл хуваарилах;

5) Инновацийн багцийн оролцогч нарыг шаардлагатай байраар хангах;

6) Инновацийн багцийн оролцогч нарыг Их сургуулийн болон бүтцийн байгууллагын лаборатори, номын санг ашиглах боломжоор хангах;

7) Их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлөөр тодорхойлсон бусад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд.

### **13 дугаар зүйл. Бусад.**

1. Энэхүү хууль нь албан ёсоор нийтлэгдсэнээс арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хуулийг хэрэгжиж эхэлснээс хойш зургаан сарын дараа үүсгэн байгуулагч нь байгаа хуулийн этгээдийг өөрчлөх замаар улсын төсвийн тусламжтайгаар Их сургууль болон Оюуны сургуулиудыг байгуулах шийдвэрийг гаргана.

3. Их сургууль, Оюуны сургуулиуд болон Сангийн Дээд төлөөлөн удирдах зөвлөлөөр дүрэм батлагдах хүртэл үйл ажиллагаа үүсгэн байгуулагчийн баталсан дүрмээр явагдана.

**ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА ХААГЧДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ХАРЬЦУУЛАЛТ /хуулиас түүвэрлэсэн судалгаа/**

*/Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна/*

<b>Цагдаагийн байгууллага</b>  <i>/Цагдаагийн албаны тухай хуулиас/</i>	<b>Хил хамгаалах байгууллага</b>  <i>/Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын хилийн тухай хуулиас/</i>	<b>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага</b>  <i>/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас/</i>	<b>Онцгой байдлын байгууллага</b>  <i>/Гамшгаас хамгаалах тухай хуулиас/</i>
<b>Эрх, үүрэг</b>			
<p>Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p><b>5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрх</b></p> <p>5.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг эрхтэй:</p> <p>5.1.1.байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал, хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх;</p> <p>5.1.2.цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх;</p> <p>5.1.3.албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах;</p> <p>5.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр</p>	<p>273.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь энэ хуулийн 271, 272 дугаар зүйлд зааснаас гадна Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>273.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулиар хориглосон үйл ажиллагаанаас гадна дараахь зүйлийг хориглоно:</p> <p>273.2.1.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах;</p> <p>273.2.2.албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах;</p> <p>273.2.3.бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрд хохирол учруулж болзошгүй мэдээ, мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх;</p>	<p><b>47 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх</b></p> <p>47.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ:</p> <p>47.1.1.гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;</p> <p>47.1.2.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх.</p> <p><b>48 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба</b></p>

	<p>цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах;</p> <p>5.1.5.мэргэжил, мэргэшил, ур чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох;</p> <p>5.1.6.эрүүл мэндээ хамгаалуулах;</p> <p>5.1.7.цэргийн алба хаах үүргээ гүйцэтгэх явцад өөрийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлоо хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэх.</p> <p><b>6 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн үүрэг</b></p> <p>6.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг үүрэгтэй:</p> <p>6.1.1.эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх;</p> <p>6.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх;</p> <p>6.1.3.Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлэх;</p> <p>6.1.4.албан тушаалын үүргээ биелүүлэх;</p> <p>6.1.5.захирах, захирагдах зарчмыг</p>	<p>273.2.4.төр, байгууллага, хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх;</p> <p>273.2.5.албан үүргээ гүйцэтгэх болон албаны бэлэн байдал зарласан үед, ажлын байранд болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;</p> <p>273.2.6.мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;</p> <p>273.2.7.бусдыг хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг уриалах, чиглүүлэх, шууд болон шууд бус хэлбэрээр өдөөн хатгах, оролцох;</p> <p>273.2.8.нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>273.2.9.удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, тушаалыг биелүүлэхээс татгалзах;</p> <p>273.2.10.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилогдсон ажилд очихгүй байх, ажил хаях, албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт</p>	<p><b>хаагчийн үүрэг</b></p> <p>48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:</p> <p>48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;</p> <p>48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;</p> <p>48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.</p>
--	---	--	--

	<p>мөрдөх;</p> <p>6.1.6.гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх;</p> <p>6.1.7.цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;</p> <p>6.1.8.хариуцсан зэвсэг, цэргийн техникийг чадамгай эзэмшиж, хамгаалах;</p> <p>6.1.9.төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцыг алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх;</p> <p>6.1.10.мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх.</p> <p>6.2.Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй.</p> <p>6.3.Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.</p>	<p>оролцох;</p> <p>273.2.11.иргэний давхар харьяалалтай байх;</p> <p>273.2.12.гэмт хэрэг, зөрчлийн талаар хүнээс мэдээлэл, тайлбар авах зорилгоор эрүүдэн шүүх, эсхүл ийм үйлдлийг аливаа хэлбэрээр зөвтгөх;</p> <p>273.2.13.хуулиар хориглосон бусад.</p> <p>273.3.Алба хаагч нь албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр нэг нь нөгөөдөө захирагч, захирагдагч байна.</p>	
<b>Улс төрийн баталгаа</b>			
<p><b>84 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа</b></p> <p>84.1.Цагдаагийн алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.</p> <p>84.2.Цагдаагийн алба</p>		<p>284.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.</p> <p>284.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг энэ хуулийн 284.1-д заасан үйл ажиллагаанд</p>	

<p>хаагчийг энэ хуулийн 84.1-д заасан үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.</p> <p>84.3.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.</p> <p>84.4.Цагдаагийн байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно.</p> <p>84.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.</p>		<p>оролцохыг шаардсан бол татгалзана.</p> <p>284.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.</p> <p>284.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно.</p> <p>284.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.</p>	
<b>Хууль зүйн баталгаа</b>			
<p><b>85 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа</b></p> <p>85.1.Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу тавьсан шаардлагыг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан, заавал биелүүлэх бөгөөд биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>85.2.Иргэн, албан тушаалтан хэн боловч цагдаагийн алба</p>	<p>39.1.Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэн нь төрийн төлөөлөгч байж, улсын эрх ашгийн үүднээс иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих, түүний биелэлтийг хангуулах эрхтэй.</p>	<p>285.1.Иргэн, албан тушаалтан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.</p> <p>285.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ хууль ёсоор гүйцэтгэснээс үүссэн</p>	

<p>хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.</p> <p>85.3.Цагдаагийн алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.</p> <p>85.4.Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс учирсан хохирлыг төр хариуцна.</p> <p>85.5.Цагдаагийн алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.</p> <p>85.6.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг цагдаагийн байгууллага хариуцна.</p> <p>85.7.Дотоод хяналт-аюулгүй байдлын алба хаагчийг тус нэгжийн даргад мэдэгдэхгүйгээр томилох, өөрчлөх, чөлөөлөхийг хориглоно.</p> <p>85.8.Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас</p>		<p>хохирлыг хариуцахгүй.</p> <p>285.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ажлын бус цагаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.</p> <p>285.4.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна.</p> <p>285.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.</p>	
--	--	--	--

<p>шалгасан, баривчилсан, цагдан хорьсон, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийсэн бол шууд удирдах даргад нь даруй мэдэгдэнэ.</p> <p>85.9.Цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд, бусад алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.</p> <p>85.10.Тайван цагт цагдаагийн алба хааж байгаа иргэнийг цэргийн жинхэнэ албанд татахаас чөлөөлөх бөгөөд цагдаагийн албанд 2-оос дээш жил ажилласан бол цэргийн албыг биеэр хаасанд тооцно.</p> <p>85.11.Цэргийн жинхэнэ алба хаагаагүй 18-25 насны цагдаагийн алба хаагчид цэргийн бэлтгэл эзэмшүүлэх үүргийг цагдаагийн төв байгууллага хүлээх ба цэргийн бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөрийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаар батлуулж, мөрдөнө.</p> <p>85.12.Хуульд зааснаас бусад үндэслэлээр цагдаагийн алба хаагчийг ажлаас чөлөөлөх, халах, өөр</p>			
--	--	--	--

ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.			
<b>Нийгмийн баталгаа</b>			
<p><b>86 дугаар зүйл.</b> <b>Нийгмийн баталгаа</b></p> <p>86.1.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.</p> <p>86.2.Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцлал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.</p> <p>86.3.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараахь нөхөх олговор, тусламж олгоно:</p> <p>86.3.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг</p>	<p>39.2.Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.</p> <p>39.3.Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна.</p> <p>39.4.Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.</p> <p>39.5.Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангагдах бөгөөд хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар</p>	<p>286.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.</p> <p>286.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 286.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.</p> <p>286.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараахь нөхөх олговор, тусламж олгоно:</p> <p>286.3.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;</p> <p>286.3.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;</p> <p>286.3.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр</p>	<p>50.6.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p> <p>50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.</p>

<p>удаагийн нөхөх олговор;</p> <p>86.3.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;</p> <p>86.3.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.</p> <p>86.4.Цагдаагийн алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрд энэ хуулийн 86.3.3-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.</p> <p>86.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 86.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.</p> <p>86.6.Энэ хуулийн 86.1-д заасан зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.</p> <p>86.7.Цагдаагийн алба хаагчид эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэг бүхий тусгай зориулалтын эмнэлэг нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, өндөржүүлсэн бэлэн байдал, онц байдал зарласан, хээрийн сургууль, дадлагын үеэр эмнэлгийн баг</p>	<p>тогтооно.</p> <p>39.6.Хилчин, түүний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал хоёр жилд нэг удаа ирэх, очих унааны зардлыг төр хариуцна.</p>	<p>авагчид авч байсан цалингийн зөрүү.</p> <p>286.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрд энэ хуулийн 286.3.3-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.</p> <p>286.5.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.</p> <p>286.6.Энэ хуулийн 286.1-д заасан зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх бөгөөд энэ хуулийн 286.3-т заасан нөхөх олговор, тусламж олгох журам, 286.5-д заасан зардал олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>286.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад 1 жил ажилласан хугацааг</p>
--	--	---

<p>ажиллуулна.</p> <p>86.8.Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>86.9.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ.</p> <p>86.10.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, эдгээр үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.</p> <p>86.11.Гэмт хэрэгтэй тэмцэх, дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна.</p> <p>86.12.Энэ зүйлд заасан нөхөх олговор, мөнгөн тусламж олгох журам,</p>		<p>1 жил 2 сар ажилласанд тооцно.</p> <p>286.8.Хорих ангийн алба хаагчийг эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай нь холбоотойгоор шаардлагатай бол 1 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулна.</p>	
---	--	---	--

<p>энэ хуулийн 86.9-д заасан үнэ төлбөргүй эмчилгээ хийх эмнэлгийн жагсаалт, энэ хуулийн 86.10-т заасан зардал олгох журам, энэ хуулийн 86.11-т заасан сэтгэлзүйн нөхөн сэргээх эмчилгээ хийх журмыг тус тус Засгийн газар батална.</p>			
<b>Эдийн засгийн баталгаа</b>			
<p><b>87 дугаар зүйл. Эдийн засгийн баталгаа</b></p> <p>87.1.Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>87.2.Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.</p> <p>87.3.Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.</p> <p>87.4.Нийтийг хамарсан эмх замбараагүй</p>	<p>39.7.Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.</p> <p>39.8.Энэ хуулийн 39.2, 39.3-т заасан иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн сарын үндсэн цалинг улсын хил хамгаалах байгууллагын ахлагчийн цалинтай адилтган тооцно.</p>	<p>287.1.Засгийн газар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>287.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжид түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.</p> <p>287.3.Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.</p>	<p>50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно.</p> <p>50.2.Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.</p> <p>50.3.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.</p> <p>50.4.Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд</p>

<p>байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.</p> <p>87.5.Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно.</p> <p>87.6.Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.</p> <p>87.7.Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс,</p>		<p>287.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.</p> <p>287.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>287.6.Аймаг, хот хооронд түүнчлэн аймаг, хот дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжин ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүнд уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын тээврийн үнэлгээгээр тооцож олгоно.</p> <p>287.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар гадаад улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.</p> <p>287.8.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс</p>	<p>хамрагдана.</p> <p>50.5.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.</p> <p>50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.</p>
---	--	--	--

<p>ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.</p> <p>87.8.Энэ хуулийн 87.7-д заасан сургуульд цагдаагийн байгууллагын захиалгаар суралцаж байгаа сонсогчийн дүрэмт хувцасны болон ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.</p> <p>87.9.Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:</p>		<p>бүрдэнэ:</p> <p>287.8.1.төрийн тусгай алба хаасан хугацааны;</p> <p>287.8.2.албан ажлын онцгой нөхцөлийн;</p> <p>287.8.3.хоригдолтой ажилласны;</p> <p>287.8.4.мэргэжлийн зэргийн;</p> <p>287.8.5.эрдмийн зэрэг, цолны;</p> <p>287.8.6.хуульд заасан бусад.</p> <p>287.9.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>287.10.Энэ хуулийн 287.8-д заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох цалин хөлсний нэмэгдлийн хэмжээ нь Төрийн албаны тухай хуулийн 28.12-т заасан зохицуулалтад хамаарахгүй.</p>	
--	--	---	--